# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 29 (314)

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ:

- *Зарим хүнд гавьяат цол хүртээж, одон, медалиар шагнасан тухай*

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ:

- *"Говь" хувьцаат компанийн хувьцааг худалдах тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар
Улаанбаатар хот
2003 он

# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот 2003 оны наймдугаар сарын 6 № 29 (314)


## Гарчиг


### Нэг. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

| | | | |
|---|---|---|---|
| 454. | Зарим хүнийг одон, медалиар шагнах тухай | Дугаар 126 | 733 |
| 455. | Аюушийн Цэвээнд Монгол Улсын гавьяат тамирчин цол хүртээх тухай | Дугаар 127 | 739 |
| 456. | Дугаржавын Намсрайд Монгол Улсын гавьяат барилгачин цол хүртээх тухай | Дугаар 128 | 739 |

### Хоёр. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

| | | | |
|---|---|---|---|
| 457. | Зарим хүнийг ажлаас чөлөөлөх, ажилд томилох тухай | Дугаар 128 | 740 |
| 458. | Д.Гунцагийг ажилд томилох тухай | Дугаар 129 | 740 |
| 459. | "Говь" хувьцаат компанийн хувьцааг худалдах тухай | Дугаар 131 | 740 |


## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

**2003 оны 7 дугаар сарын 8-ны өдөр** **Дугаар 126** **Улаанбаатар хот**

**Зарим хүнийг одон, медалиар шагнах тухай**

Үйлдвэрлэл, үйлчилгээ, боловсрол, эрүүл мэнд, хууль, санхүү, гадаад харилцаа, төр захиргааны болон төрийн бус байгууллагад олон жил амжилт гарган үр бүтээлтэй ажиллаж байгаа дор дурдсан хүмүүсийг одон, медалиар шагнасугай.

**ХӨДӨЛМӨРИЙН ГАВЬЯАНЫ УЛААН ТУГИЙН ОДОНГООР:**

1. Тумэнгийн Баярсайхан -Хөвсгөл аймгийн Тосонцэнгэл сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн дарга
2. Хайвангийн Дугэр -Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны харьяа албан бус боловсролын төвийн зөвлөх
3. Шархүүгийн Дэжээхүү -Увс аймгийн Зүүнхангай сумын Хүн эмнэлгийн их эмч
4. Дамдингийн Мижиддорж -Нийслэлийн 31 дүгээр дунд сургуулийн түүхийн багш
5. Дагвын Цахилгаан -Гадаад хэргийн сайдын зөвлөх

**ЦЭРГИЙН ГАВЬЯАНЫ УЛААН ТУГИЙН ОДОНГООР:**

1. Азадын Баатарцогт -Монгол Улсаас ОХУ-д суугаа Элчин сайдын яамны нэгдүгээр нарийн бичгийн дарга, хилийн албан ёсны төлөөлөгч
2. Жамсранжавын Бадамдорж -Булган аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын дарга, хурандаа
3. Сайнбилэгийн Сийзхүү -Тагнуулын ерөнхий газрын Гадаад тагнуулын газрын дарга, хурандаа

**"АЛТАН ГАДАС" ОДОНГООР:**

| | |
|---|---|
| 1. Нягуурын Агваан | -Худалдаа үйлдвэрлэлийн дээд сургуулийн тэнхмийн эрхлэгч |
| 2. Гарамын Ариунаа | -Стандарчилал хэмжилзүйн үндэсний төвийн лабораторийн эрхлэгч |
| 3. Хайдавын Бадам | -Улсын мэргэжлийн хяналтын газрын улсын ахлах байцаагч |
| 4. Ишдоржийн Батаа | -Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лабораторийн малын их эмч |
| 5. Сэрээтэрийн Батсүх | -МОНЦАМЭ агентлагийн гэрэл зургийн сурвалжлагч |
| 6. Сандагийн Баянхүү | -Дорноговь аймгийн Холбооны газрын дарга |
| 7. Дашнямын Болдбаатар | -Орхон аймаг дахь Монгол-Оросын хамтарсан уулын баяжуулах "Эрдэнэт" үйлдвэрийн ерөнхий захирлын орлогч |
| 8. Жамбалын Бямба | -Дорноговь аймгийн Эрдэнэ сумын хүн эмнэлгийн эх баригч бага эмч |
| 9. Бадамын Гүррагчаа | -Нийслэлийн Баянзүрх дүүргийн Татварын хэлтсийн тасгийн дарга |
| 10. Жамбалдоржийн Даваадулам | -Хөвсгөл аймгийн Мөрөн сумын "Дэлгэрмөрөн" цогцолбор дунд сургуулийн газар зүйн багш |
| 11. Отгонбаярын Даваасамбуу | -Газрын тосны хэрэг эрхлэх газрын дарга |
| 12. Дарийн Дамдин | -Худалдаа үйлдвэрлэлийн дээд сургуулийн багш |
| 13. Зандраагийн Дармаа | -Зэвсэгт хүчний 232 дугаар ангийн механик инженер |
| 14. Чулуунжавын Долгорсүрэн | -Ховд аймгийн Жаргалант сумын өдөр настан |
| 15. Мухапын Каспий | -Баян-Өлгий аймгийн Булган сумын дунд сургуулийн дүрслэх урлагийн багш |
| 16. Хойшыбайн Лазихан | -Баян-Өлгий аймгийн нэгдсэн эмнэлгийн мэдрэлийн тасгийн эрхлэгч, их эмч |
| 17. Чойдоржийн Лхагвасүрэн | -Дэд бүтцийн яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, эдийн засгийн газрын ахлах мэргэжилтэн |
| 18. Гэндэнгийн Малигар | -Баянхонгор аймгийн Баян-Өндөр сумын ахмадын хорооны дарга |
| 19. Сундуйн Махбал | -Нийслэлийн Нийгмийн даатгалын газрын бүртгэл, санхүү, тооцоололтын хэлтсийн дарга |
| 20. Цэсэнжавын Мөнхтогоо | -Дорноговь аймгийн Мандах сумын Иргэдийн төлөөлөгчийн хурлын Тэргүүлэгчдийн дарга |
| 21. Довчингийн Наваан | -Өвөрхангай аймгийн Нэгдсэн эмнэлгийн Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн нойрсуулагч эмч |
| 22. Баярын Нацагдорж | -Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын дунд сургуулийн орос хэлний багш |
| 23. Дэмбэрэлийн Норжинсүрэн | -Улаанбаатар төмөр замын "Баянбуурал" амралтын газрын ерөнхий нягтлан бодогч |
| 24. Аюурын Одхүү | -Хөвсгөл аймгийн Ринчинлхүмбэ сумын дунд сургуулийн биеийн тамирын багш |
| 25. Цэдэнгийн Очирдулам | -Сонгинохайрхан дүүргийн Эрүүл мэндийн нэгдлийн 3 дугаар амбулаторийн эрхэгч |
| 26. Балхүүгийн Оюунцэцэг | -Монгол Улсын их сургуулийн ерөнхий нягтлан бодогч |
| 27. Шаадайн Өвдөл | -"Хадгаламж" банкны Орхон аймаг дахь 1604 дүгээр салбарын захирал |
| 28. Баяндалайн Пүрэвжав | -Ховд аймгийн Ховд сумын Баруун салаа багийн малчин |
| 29. Чойжинжавын Пүрэвсүрэн | -Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Барилга, хот байгуулалт, нийтийн аж ахуйн газрын мэргэжилтэн |
| 30. Шагдарын Самбуу | -Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Авто тээврийн газрын эдийн засагч |
| 31. Лхамжавын Сарангэрэл | Нийслэлийн Чингэлтэй дүүргийн шүүхийн ерөнхий шүүгч |
| 32. Капын Саяси | -Баян-Өлгий аймгийн Алтай сумын Татварын |

| | |
|---|---|
| | хэлтсийн улсын байцаагч |
| 33. Эрдэнэдаваагийн Сүхбаатар | -Булган аймгийн Театр хүрээлэнгийн найрал дууны багш |
| 34. Домбожавын Сүхээ | -Анагаах ухааны их сургуулийн багш, Эх нялхсын эрдэм шинжилгээний төвийн зөвлөх эмч |
| 35. Доржийн Тайванхүү | -Ховд аймгийн шүүхийн ерөнхий шүүгч |
| 36. Долгорын Тогоо | -МАХН-ын Өмнөговь аймгийн хорооны дэд дарга |
| 37. Лувсанжамцын Удвал | -Гадаад хэргийн яамны Европ, Араб, Африкийн газрын захирал |
| 38. Лоолойн Уламбаяр | -П.Н.Шастины нэрэмжит клиникийн төв эмнэлгийн дотрын тасгийн эрхлэгч |
| 39. Цэдэндамбын Уламбаяр | -"Төвийн бүсийн цахилгаан дамжуулах сүлжээ" ХК-ийн санхүүгийн хэлтсийн дарга |
| 40. Хызырын Хажайхан | -Баян-Өлгий аймгийн Ногооннуур сумын дунд сургуулийн захирал |
| 41. Улагваны Хайрылыс | -Баян-Өлгий аймгийн Өлгий сумын 1 дүгээр сургуулийн монгол хэл, уран зохиолын багш |
| 42. Ядамын Халтархүү | -Орхон аймгийн статистикийн хэлтсийн статистикч |
| 43. Балтын Хөхгэрэлт | -Дархан-Уул аймгийн "Гэрэлт" хувийн эмнэлгийн их эмч |
| 44. Жигмэддаганийн Хүрэлсүх | -Стандартчилал хэмжил зүйн үндэсний төвийн дарга |
| 45. Найдангийн Хүрэлчулуун | -Улсын мэргэжлийн хяналтын газрын санхүүгийн хяналт шалгалтын хэлтсийн улсын ахлах байцаагч |
| 46. Цээсүрэнгийн Цогтсайхан | -Нийслэлийн Баянзүрх дүүргийн Тохижилт үйлчилгээний компанийн захирал |
| 47. Цэвээний Цоодол | -Өвөрхангай аймгийн Хайрхандулаан сумын Засаг даргын Тамгын газрын түшмэл |
| 48. Балжаагийн Цэвээнжав | -Ховд аймгийн Манхан сумын малчин |
| 49. Монхооны Цэдэнжав | -Хөвсгөл аймгийн Аудитын газрын ерөнхий аудиторч |
| 50. Цэнд-Аюушийн Цэрэндэжид | -Хөвсгөл аймгийн Мөрөн сумын 1 дүгээр дунд сургуулийн химийн багш |
| 51. Должингийн Цэрэнпагма | -Баянхонгор аймгийн Галуут сумын хүн эмнэлгийн эх баригч, бага эмч |
| 52. Лувсанцэрэнгийн Цэрэнхорлоо | -Хөвсгөл аймгийн Мөрөн сумын 1 дүгээр дунд сургуулийн бага ангийн багш |
| 53. Данзан-Осорын Шааривбуу | -Сүхбаатар аймгийн мэргэжлийн хяналтын газрын хяналтын улсын байцаагч |
| 54. Руламын Шатар | -Нийслэлийн хүүхдийн "Сэлбэ" зуслангийн нягтлан бодогч |
| 55. Жөмбөгөрийн Шатарбал | -Баянхонгор аймгийн Баян-өндөр сумын 3 дугаар багийн малчин |
| 56. Чойживын Элбэгзаяа | -Өвөрхангай аймгийн Баян-Өндөр сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн дарга |
| 57. Тогоогийн Энхболд | -Монгол Улсаас ОХУ-д суугаа Элчин сайдын яамны атташе |
| 58. Чимэддоржийн Эрдэнэ | -Улсын мэргэжлийн хяналтын газрын улсын байцаагч |
| 59. Цэрэндоржийн Эрдэнэ-Очир | -Баянхонгор аймгийн Эрдэнэцогт сумын ИТХТ-ийн дарга |

**ЦЭРГИЙН ГАВЬЯАНЫ ОДОНГООР:**

| | |
|---|---|
| 1. Эрдэнэдавгын Батмөнх | -Тагнуулын ерөнхий газрын барилга ангийн дарга, хурандаа |
| 2. Түвдэнгийн Дашнамжил | -Зэвсэгт хүчний 016 дугаар ангийн авто техникийн дарга, дэд хурандаа |
| 3. Сүрэнхорлоогийн Мөнхнасан | -Орхон аймгийн Засаг даргын Тамгын газрын цэрэг, иргэний хамгаалалтын штабын дарга, хурандаа |
| 4. Цээгсүрэнгийн Тогоо | -Зэвсэгт хүчний жанжин штабын дарга, хошууч генерал |
| 5. Оргийн Цэрэндэмбэрэл | -Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийн дотрын тасгийн эрхлэгч, дэд хурандаа |

**ХӨДӨЛМӨРИЙН ХҮНДЭТ МЕДАЛИАР:**

1. Мөнхийн Авирмэд -Улсын мэргэжлийн хяналтын газрын эмчилгээний чанарын улсын байцаагч
2. Ядамсүрэнгийн Алагбанди -Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Барилга, хот байгуулалт, нийтийн аж ахуйн газрын мэргэжилтэн
3. Цэнджавын Алгаа -Говь-Алтай аймгийн Стандарчлал хэмжил зүйн төвийн захирал
4. Дагважамцын Алтанцэцэг -Нийслэлийн Татварын газрын улсын байцаагч
5. Халзангийн Алтанцэцэг -Дорноговь аймгийн Даланжаргалан сумын нийгмийн даатгалын байцаагч
6. Билдиханы Аманкелди -Баян-Өлгий аймгийн Бугат сумын дунд сургуулийн бага ангийн багш
7. Агваандаржаагийн Баасанжав -Шүүхийн ерөнхий зөвлөлийн ерөнхий нягтлан бодогч
8. Ганжуурын Баасанжав -Хөвсгөл аймгийн "Эм хангамж" компанийн 1 дүгээр эмийн сангийн эм найруулагч
9. Ванданжавын Баатаржав -Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн Тохижилт үйлчилгээний /УҮГ/ компанийн жолооч
10. Жигжидийн Базаргүр -Дорнод аймгийн Хэрлэн сумын 6 дугаар багийн Засаг дарга
11. Тогтохбаярын Батбаатар -Гадаад хэргийн яамны Төрийн захиргаа, удирдлагын газрын 1 дүгээр нарийн бичгийн дарга
12. Дамдингийн Батжаргал -Увс аймгийн Баруунтуруун сумын хүнс, хөдөө аж ахуйн "Зүүнтуруун" ХХК-ийн механикч
13. Дашдаваагийн Бат-Очир -Үндэсний архивын газрын хэвлэлийн технологич инженер
14. Мөнхөөгийн Баярхүү -"Монгол даатгал" компанийн ахлах нягтлан бодогч
15. Жамсранжавын Баясгалан -Нийслэлийн Татварын газрын татварын улсын байцаагч
16. Сүх-Очирын Болд -Гадаад хэргийн яамны Эрх зүй, консулын газрын захирал
17. Багвааны Борхүү -Нийслэлийн Чингэлтэй дүүргийн Татварын хэлтсийн тасгийн дарга
18. Жамбалын Бумдарь -Дорноговь аймгийн Сайншанд сумын 3 дугаар дунд сургуулийн монгол хэл, уран зохиолын багш
19. Гомбосүрэнгийн Буяннэмэх -Улсын Дээд шүүхийн иргэний хэргийн танхимын шүүгчийн туслах
20. Чойндонгийн Бэхбат -Дархан-Уул аймгийн Орхон сумын 8 дугаар дунд сургуулийн биеийн тамирын багш
21. Сугирын Бямбаа -Өмнөговь аймгийн Стандарчлал, хэмжил зүйн төвийн дарга
22. Бадамраагийн Галбадрах -Улсын мэргэжлийн хяналтын газрын хөдөлмөрийн хяналтын улсын ахлах байцаагч
23. Чулуунбаатарын Ганбат -Ховд аймгийн Цэцэг сумын Засаг дарга
24. Тогтохын Дамдинсүрэн -Сүхбаатар аймгийн Баяндэлгэр сумын татварын улсын байцаагч
25. Гарамын Дарьсүрэн -Улсын мэргэжлийн хяналтын газрын нэгдсэн төв лабораторийн химийн лаборант
26. Дугарын Дашдаваа -Дорнод аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтсийн эдийн засагч
27. Цэвэгжавын Долгоржав -Хөвсгөл аймгийн Мөрөн сумын 1 дүгээр дунд сургуулийн бага ангийн багш
28. Сономын Долгорсүрэн -ХААН банкны Өвөрхангай аймгийн Сант сум дахь салбарын тооцооны нягтлан бодогч
29. Сэржмядагийн Дулмаа -Дундговь аймгийн Дэлгэрцогт сумын дунд сургуулийн бага ангийн багш
30. Долгорын Дэжид -Хөвсгөл аймгийн Мөрөн сумын 1 дүгээр цэцэрлэгийн багш
31. Ширчиндоогийн Ёндонноров -Дорноговь аймаг дахь УБТЗ-ын Сайншанд өртөө зангилааны дарга

32. Балжиннямын Жамбал -Дундговь аймгийн Дэлгэрцогт сумын "Нэгдмэл хөдөлгөөн" хоршооны дарга

33. Дашзэвэгийн Жамьян -Дархан-Уул аймгийн Орхон сумын Хүн эмнэлгийн эх баригч бага эмч

34. Даваадоржийн Жаргалсайхан -Дархан-Уул аймгийн "Ичинстекстайль" ХХК-ийн оёдлын үйлдвэрийн захирал

35.Жамбалсүрэнгийн Ирина -Төрийн тусгай хамгаалалтын газрын боловсон хүчний ажилтан

36. Цэвээндоржийн Ичинхорлоо Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийн биохимийн лаборант

37. Адъяагийн Лхагвадорж -Газрын тосны хэрэг эрхлэх газрын ахлах мэргэжилтэн

38. Санжаагийн Лхамсүрэн -Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн Татварын хэлтсийн татварын улсын байцаагч

39. Осорын Мөнхтуяа -Улсын мэргэжлийн хяналтын газрын нэгдсэн төв лабораторийн нян судлагч эмч

40. Чойжамцын Мөнхчулуун -"Төвийн бүсийн цахилгаан дамжуулах сүлжээ" ХК-ийн холбооны ахлах инженер

41. Даваажавын Намжилмаа -Нийслэлийн Баянгол дүүргийн 13 дугаар дунд сургуулийн математикийн багш

42. Жаргалсайханы Намжим -Дорнод аймгийн Чойбалсан сумын Хүн эмнэлгийн эх баригч бага эмч

43. Баянзулын Наранхүү -Нийслэлийн өмчийн газрын мэргэжилтэн

44.Жанцансамбуугийн Насанбалжид -Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийн ахлах сувилагч

45. Мягмарын Нацаг -Нийслэлийн худалдаа, үйлчилгээний "Дэлгээн нуур" ХХК-ийн ерөнхий нягтлан бодогч

46. Өлзийн Нүрмээ -Хөвсгөл аймгийн "Эм хангамж" компанийн 1 дүгээр эмийн сангийн эрхлэгч

47. Цогтын Нямхүү -Нийслэлийн Татварын газрын улсын ахлах байцаагч

48. Дашзэвэгийн Оюун -Өвөрхангай аймгийн Баянгол сумын татварын улсын байцаагч

49. Цэвээнпүрэвийн Оюун -Нийслэлийн засаг даргын дэргэдэх Боловсролын газрын түшмэл

50. Мөнхөөгийн Оюунбаатар -Нийслэлийн зорчигч тээврийн "Автобус-1" компани /ҮҮГ/-ийн жолооч

51. Гүнчингийн Оюунчимэг -Эрүүл мэндийн яамны харъяа Цусны төвийн ахлах бага эмч

52. Цэрэндоржийн Өлзийжаргал -Нийслэлийн Чингэлтэй дүүргийн 37 дугаар дунд сургуулийн захирал

53. Дамбадоржийн Өлзий-Орших -Баянхонгор аймгийн Богд сумын хүн эмнэлгийн ерөнхий эмч

54. Дэжидийн Өлзийтогтох -Гадаад хэргийн яамны Дипломат байгууллагын үйлчилгээ, аж ахуйн газрын сантехникч

55. Дунгээгийн Пунцаг -Дархан-Уул аймгийн Орхон сумын 2 дугаар багийн малчин

56. Цэдэнгомбын Пүрэвжаргал -Гадаад хэргийн яамны Хөрш орнуудын газрын дэд захирал

57. Чойжинжавын Пүрэвсүрэн -Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Барилга, хот байгуулалт, нийтийн аж ахуйн газрын ахлах мэргэжилтэн

58. Куришбекийн Разига -Баян-Өлгий аймгийн Эрүүл мэндийн газрын бага эмч

59. Зияданы Раушан -Баян-Өлгий аймгийн Улаанхус сумын дунд сургуулийн бага ангийн багш

60. Батмөнхийн Рэгзэдмаа -Гадаад хэргийн яамны Дипломат байгууллагын үйлчилгээ, аж ахуйн газрын барилгын даамал

61. Онжилийн Сайзмаа -Нийслэлийн "Үрийн заяа" эмэгтэйчүүдийн хувийн эмнэлгийн их эмч

62. Цэдэндамбын Сайзмаа -Эрүүл мэндийн яамны харъяа Цусны төвийн бага эмч

63. Гонгоржавын Сарантуяа -Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Барилга, хот байгуулалт, нийтийн аж ахуйн газрын мэргэжилтэн

64. Магнайн Содном -Ховд аймгийн Чандмань сумын Баянхайрхан багийн

малчин

65. Лувсансүрэнгийн Сундуйхүү -Булган аймгийн Татварын хэлтсийн татварын улсын ахлах байцаагч

66. Намжилын Сүхбаатар -Өмнөговь аймгийн Ноён сумын Хүн эмнэлгийн эх баригч бага эмч

67. Цэдэндамбын Сүхбат -Орхон аймгийн Орон сууц хувьчлалын товчооны салбар зөвлөлийн дарга

68. Сонгобайн Татьяна -Улсын мэргэжлийн хяналтын газрын улсын байцаагч

69. Дооровын Тогтох -Дорноговь аймгийн Сайншанд сумын 3 дугаар дунд сургуулийн бага ангийн багш

70. Базарын Төмөрбаатар -Дорноговь аймгийн "Саран хөхөө" театрын жүжигчин

71. Сэдэнгийн Төмөрзүрх -Дорнод аймгийн Булган сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн дарга

72. Минжжамбаалийн Төмөрчулуун -Сүхбаатар аймгийн Засаг даргын Тамгын газрын төрийн сангийн хэлтсийн дарга

73. Таяын Төрбат -Увс аймгийн Давст сумын 1 дүгээр багийн Засаг дарга

74. Түдэвбазарын Туул -Байгаль орчны яамны санхүү, төсвийн хэлтсийн дарга

75. Хайрдарын Хызай -Баян-Өлгий аймгийн Толбо сумын дунд сургуулийн бага ангийн багш

76. Цэдэвийн Хөвсгөлдалай -Хөвсгөл аймгийн Тариалан сумын Засаг дарга

77. Хатраны Хуандаг -Баян-Өлгий аймгийн Нэгдсэн эмнэлгийн сүрьеэгийн диспансерийн тасгийн эрхлэгч

78. Ядамын Цэвэгмид -Нийслэлийн Сүхбаатар дүүргийн Татварын хэлтсийн татварын улсын байцаагч

79. Жанцангийн Цэвээнжав -П.Н.Шастины нэрэмжит Клиникийн төв эмнэлгийн чих хамар хоолойн мэс заслын их эмч

80. Оргийн Цэдэндамба -Эрүүл мэндийн яамны харьяа Цусны төвийн ариутгагч

81. Арслангийн Цэдэнсодном -"Алтайн барс" бөхийн клубын дасгалжуулагч

82. Дамдингийн Цэрмаа -Говь-Алтай аймгийн Жаргалан сумын хүн эмнэлгийн эрхлэгч, их эмч

83. Надмидын Цэрмаа -Нийслэлийн Налайх дүүргийн Эрүүл мэндийн нэгдлийн их эмч

84. Боовонгийн Цэрэнбат -Иргэний нисэхийн ерөнхий газрын нягтлан бодогч

85. Цэнд-Очирын Цэрэндорж -Улаабаатар төмөр замын "Баянбуурал" амралтын газрын дарга

86. Жанцангийн Чимэдрэгзэн -Нийслэлийн Баянгол дүүргийн 13 дугаар дунд сургуулийн сургалтын менежер

87. Гэлгээгийн Чулуунцэцэг -Хөвсгөл аймгийн Эрүүл мэндийн газрын нөхөн үржихүйн кабинетийн бага эмч

88. Сумъяагийн Чулуунцэцэг -Эрүүл мэндийн яамны харьяа Цусны төвийн бага эмч

89. Гомбо-Очирын Шаравдорж -Гадаад хэргийн яамны Дипломат байгууллагын үйлчилгээ, аж ахуйн газрын жолооч

90. Дамдингийн Шаравдорж -Стандарчилал, хэмжилзүйн үндэсний төвийн ахлах менежер

91. Хайсагийн Шакерхан -Баян-Өлгий аймгийн Цэнгэл сумын дунд сургуулийн биеийн тамирын багш

92. Төмөрийн Шинэбаяр -Ховд аймгийн Мөст сумын Хүн эмнэлгийн их эмч

93. Түмэнжаргалын Энхтуяа -Стандартчилал хэмжилзүйн үндэсний төвийн мэргэжилтэн

94. Хурцбаатарын Энхтуяа -Хэнтий аймгийн мэргэжлийн хяналтын газрын улсын байцаагч

95. Лувсандамбын Эрийнтовч -Хэнтий аймгийн Хэрлэн сумын 4 дүгээр дунд сургуулийн захирал

**ЦЭРГИЙН ХҮНДЭТ МЕДАЛИАР:**

1. Дамдиндоржийн Алтангэрэл -Цэргийн дуу, бүжгийн эрдмийн чуулгын дуучин, ахлах ахлагч

2. Лувсанчойдорын Батболд -Зэвсэгт хүчний 189 дүгээр ангийн цэргийн удирдлага, автоматжуулалтын төвийн

| | | | |
|---|---|---|---|
| | дарга, дэд хурандаа | | хурандаа |
| 3. Балдангийн Батмөнх | -Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийн эрүүл мэндийн төвийн эрхлэгч | 10. Лувсанбалдангийн Өлзиймөнх | -Хорих 401 дүгээр ангийн дарга, хурандаа |
| 4. Дүгэрнямын Баттулга | -Тагнуулын ерөнхий газрын 2 дугаар хэлтсийн ахлах ажилтан, дэд хурандаа | 11. Зогдын Өнөржаргал | -Зэвсэгт хүчний 310 дугаар ангийн нярав, ахлах ахлагч |
| 5. Ядмаагийн Ганбаатар | -Тагнуулын ерөнхий газрын гадаад тагнуулын ахлах ажилтан, хошууч | 12. Жигжидийн Сүхбаатар | -Дорнод аймгийн Засаг даргын Тамгын газрын цэргийн штабын дарга, дэд хурандаа |
| 6. Жаргаагийн Ганболд | -Зэвсэгт хүчний 189 дүгээр ангийн цэргийн удирдлага, автоматжуулалтын төвийн инженер, хошууч | 13. Данзангийн Пүрэвдорж | -Зэвсэгт хүчний 167 дугаар ангийн оперативын тасгийн дарга, дэд хурандаа |
| 7. Сэмжидийн Ганболд | -Зэвсэгт хүчний 327 дугаар ангийн санхүүгийн дарга, дэд хурандаа | 14. Лувсанбалдангийн Чулуун | -Тагнуулын ерөнхий газрын 1 дүгээр газрын хэлтсийн орлогч дарга, дэд хурандаа |
| 8. Жамсрангийн Жаргалсайхан | -Батлан хамгаалах яамны Зэвсэгт хүчний жанжин штабын үйлчилгээ, аж ахуйн газрын жолооч, ахлах ахлагч | 15. Сэдийн Энхтайван | -Зэвсэгт хүчний 014 дүгээр ангийн захирагчийн орлогч, дэд хурандаа |
| 9. Дайрийн Мэлс | -Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийн эмчилгээ эрхэлсэн орлогч дарга. | 16. Доржпаламын Эрдэнэцогт | -Батлан хамгаалах яамны Стратегийн удирдлага, төлөвлөлтийн газрын мэргэжилтэн, дэд хурандаа |

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

**2003 оны 7 дугаар сарын 9-ний өдөр** **Дугаар 127** **Улаанбаатар хот**

**Аюушийн Цэвээнд Монгол Улсын гавьяат тамирчин цол хүртээх тухай**

Сурын харваагаар үндэсний их баяр наадам, улсын аварга шалгаруулах тэмцээнд удаа дараа түрүүлж, дээд амжилт тогтоон, сурын спортын залгамж халааг бэлтгэх, үндэсний сурын харваанг хөгжүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж ахмад харваач Аюушийн Цэвээнд Монгол Улсын гавьяат тамирчин цол хүртээсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

**2003 оны 7 дугаар сарын 9-ний өдөр** **Дугаар 128** **Улаанбаатар хот**

**Дугаржавын Намсрайд Монгол Улсын гавьяат барилгачин цол хүртээх тухай**

Барилгын үйлдвэрлэлийн салбарт олон жил санаачилга, үр бүтээлтэй ажиллаж шинэ бүтээл, оновчтой санал, ашигтай загварууд гаргаж үйлдвэрлэлд нэвтрүүлэх, барилгын сантехникийн зураг төслийн тооцоог сайтар хийж, төсөвт өртгийг хямдруулах, залуу мэргэжилтнүүдийг дагалдуулан сургахад оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Нийслэлийн барилгын сантехник, автоматик угсралтын үйлдвэрлэлийн "Одкон холдинг" ХХК-ийн инженер Дугаржавын Намсрайд Монгол Улсын гавьяат барилгачин цол хүртээсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ**

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2003 оны 5 дугаар сарын 28-ны өдөр | Дугаар 128 | Улаанбаатар хот

**Зарим хүнийг ажлаас чөлөөлөх, ажилд томилох тухай**

Дипломат албаны тухай хуулийн 16.2-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Томилолтын хугацаа дууссан тул Нямын Мишигдоржийг Монгол Улсаас Оросын Холбооны Улсын Улаан-Үд хотод суугаа Ерөнхий консулын үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.

2. Монгол Улсаас Оросын Холбооны Улсын Улаан-Үд хотод суух Ерөнхий консулаар Намжилын Түмэндэмбэрэлийг томилсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

ГАДААД ХЭРГИЙН САЙД Л.ЭРДЭНЭЧУЛУУН

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2003 оны 5 дугаар сарын 28-ны өдөр | Дугаар 129 | Улаанбаатар хот

**Д.Пунцагийг ажилд томилох тухай**

Дипломат албаны тухай хуулийн 16.2-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Дарийн Пунцагийг Монгол Улсаас Оросын Холбооны Улсын Кызыл хотод суух Ерөнхий консулаар томилсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

ГАДААД ХЭРГИЙН САЙД Л.ЭРДЭНЭЧУЛУУН

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2003 оны 5 дугаар сарын 28-ны өдөр | Дугаар 131 | Улаанбаатар хот

**"Говь" хувьцаат компанийн хувьцааг худалдах тухай**

Төрийн өмчийг 2001-2004 онд хувьчлах үндсэн чиглэл, Төрийн өмчийг 2003 онд хувьчлах хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 46-54 дүгээр зүйлийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Говь" хувьцаат компанийн нийт хувьцааны төрийн эзэмшлийн 70 хувьд ногдох 5460788 (таван сая дөрвөн зуун жаран мянга долоон зуун наян найман) ширхэг хувьцааг худалдах "Уралдаант шалгаруулалт /тендер/-ын зар мэдээ"-г 1 дүгээр, "Уралдаант шалгаруулалт /тендер/-ын журам"-ыг 2 дугаар хавсралт ёсоор тус тус батлсугай.

2. "Говь" хувьцаат компанийн нийт хувьцааны төрийн эзэмшлийн 70 хувьд ногдох 5460788 ширхэг хувьцааг худалдах доод үнийг 11.6 (арван нэгэн сая зургаан зуун мянган) сая ам.доллараар тогтоосугай.

3. Төрийн өмчийн хороо (Л.ПҮРЭВДОРЖ)-нд даалгах нь:

а/"Говь" хувьцаат компанийн нийт хувьцааны төрийн эзэмшлийн 70 хувьд ногдох 5460788 ширхэг хувьцааг худалдах "Уралдаант шалгаруулалт /тендер/-ын зар мэдээ"-г дотоод, гадаадын хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлж ажилласугай;

б/"Говь" хувьцаат компанийн нийт хувьцааны төрийн эзэмшлийн 70 хувьд ногдох 5460788 ширхэг хувьцааг худалдах уралдаант шалгаруулалтыг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Уралдаант шалгаруулалт /тендер/-ын журмын дагуу зохион байгуулан явуулсугай;

в/"Говь" хувьцаат компанийн нийт хувьцааны төрийн эзэмшлийн 70 хувьд ногдох 5460788 ширхэг хувьцааг худалдах уралдаант шалгаруулалт /тендер/-т ялсан худалдан авагчтай Уралдаант шалгаруулалт /тендер/-ын журамд заасан хувьчлалын зорилгыг хэрэгжүүлэх болзол, нөхцөлийн талаар харилцан тохиролцож, Хувьцаа худалдах, худалдан авах тухай гэрээ байгуулахыг зөвшөөрсүгэй.

4. Энэ тогтоол гарсантай холбогдуулан ""Говь" хувьцаат компанийн нийт хувьцааны төрийн эзэмшлийн хувьцааг худалдах тухай" Засгийн газрын 2001 оны 7 дугаар сарын 4-ний өдрийн 155 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН САЙД Ч.УЛААН

*Засгийн газрын 2003 оны 131 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралт*

### МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР ТӨРИЙН ӨМЧИЙН ХОРОО УРАЛДААНТ ШАЛГАРУУЛАЛТ /ТЕНДЕР/-ЫН ЗАР МЭДЭЭ

Монгол Улсын Их Хурлын 2001 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 10 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн өмчийг 2001-2004 онд хувьчлах үндсэн чиглэл", Засгийн газрын 2003 оны 1 дүгээр сарын 22-ны өдрийн 14 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрийн өмчийг 2003 онд хувьчлах хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд ноолуур боловсруулах болон ноолууран бүтээгдэхүүний үйлдвэрлэл, борлуулалт эрхэлдэг "Говь" ХК (цаашид "Говь" буюу "компани" гэх)-ийн нийт хувьцааны төрийн эзэмшлийн 70 хувьд ногдох 5460788 (таван сая дөрвөн зуун жаран мянга долоон зуун наян найм) ширхэг энгийн багц хувьцааг хаалттай уралдаант шалгаруулалт /цаашид "тендер" гэх/-ын аргаар хувьчлах үйл ажиллагаанд оролцох гадаадын болон дотоодын стратегийн хөрөнгө оруулагчдыг Монгол Улсын Засгийн газар урьж байна. "Говь" ХК нь ноолууран эдлэл, бэлэн бүтээгдэхүүний үйлдвэрлэл эрхэлдэг Монгол Улсын хамгийн том компани бөгөөд ноолуурын салбар дахь дэлхийн томоохон компаниудын нэг юм.

Тендерийг Монгол Улсын Засгийн газрын 2003 оны 5 дугаар сарын 28-ны өдрийн 131 дүгээр тогтоолоор баталсан "Уралдаант шалгаруулалт / тендер/-ын журам"-д тусгагдсан нөхцөл, болзлын дагуу Төрийн өмчийн хороо /цаашид "ТӨХ" гэх/-ноос зохион байгуулж явуулна. Засгийн газрын шийдвэрээр компанийн төрийн эзэмшлийн 70 хувийг худалдах доод үнийг 11.6 (арван нэгэн сая зургаан зуун мянга) сая ам. доллараар тогтоосон болно.

"Говь" хувьцаат компанийг хувьчлах ажилд Монгол Улсын Засгийн газар болон АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлаг /ОУХА/-ийн хооронд байгуулсан гэрээний дагуу "Бэринг Пойнт" компанийн "Барентс бүлэг" нь ТӨХ-ны зөвлөхөөр ажиллаж байгаа болно.

**<u>Тендерт оролцох өргөдөл гаргах/ сонирхлоо илэрхийлэх</u>**

Оёмол, сүлжмэл эдлэл, бэлэн хувцасны үйлдвэрлэл эрхэлдэг хөрөнгө оруулагч, тэдгээрийн оролцоотой консорциум, оёмол, сүлжмэл эдлэл, бэлэн хувцасны салбарын техникийн түнш болон/ буюу менежментийн багийг хоёроос (2) доошгүй жил гэрээгээр ажиллуулах үүрэг хүлээх чадвартай санхүүгийн хөрөнгө оруулагч зэрэг шаардлага хангасан хөрөнгө оруулагчдыг өргөдөл гаргаж, сонирхлоо илэрхийлэхийг урьж байна.

Тендерийн зар мэдээ гарсны дараа тендерт оролцох хүсэлтэй этгээд /цаашид "өргөдөл гаргагч" гэх/ нь сонирхлоо илэрхийлсэн албан ёсны захидлыг дараах материалын хамт англи буюу монгол хэлний аль нэг дээр бэлтгэж ТӨХ-нд ирүүлнэ. Үүнд:

1. Өргөдөл;
2. Зохих журмын дагуу үйлдэж, өргөдөл гаргагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч гарын үсэг зурсан нууцыг хадгалах тухай гэрээ,
3. Буцааж төлөгдөхгүй нөхцөлтэй 1000 / нэг мянган/ ам. долларын тендерийн хураамж төлснийг нотлох баримт,
4. Итгэмжлэгдсэн төлөөлөгчийн төлөөлөх эрхийг баталгаажуулсан итгэмжлэл,
5. Өргөдөл гаргагчийн танилцуулга. Үүнд дараах зүйлийг оруулсан байх шаардлагатай:

- Тендерт оролцох сонирхлоо илэрхийлж буй компанийн албан ёсны нэр, хаяг болон үйл ажиллагааны танилцуулга / консорциумаар оролцож байгаа

тохиолдолд энэхүү мэдээллийг консорциумын гишүүн тус бүрээр гаргаж өгнө/,

- Оёмол, сүлжмэл эдлэл, бэлэн хувцасны салбарын хөрөнгө оруулагч, өргөдөл гаргагч болон түүний санал болгож буй техникийн түнш болон/буюу менежментийн багийн оёмол, сүлжмэл эдлэл, бэлэн хувцасны үйлдвэрлэл явуулж ирсэн туршлага чадавхийг баталсан мэдээлэл,

- Тендерт оролцож буй компанийг үүсгэн байгуулж, бүртгүүлсэн тухай баримт бичгүүд,

- Хамгийн сүүлийн санхүүгийн жилийн эцсийн байдлаар гаргаж, аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан тэнцэл буюу хувьцаат компанийн хувьд хувьцаа эзэмшигчдэд зориулсан жилийн тайлан /консорциумаар оролцож байгаа тохиолдолд энэхүү мэдээллийг консорциумын гишүүн тус бүрээр гаргаж өгнө/,

- Өргөдөл гаргагч компанийн нийт гаргасан хувьцааны 5 /тав/-аас дээш хувийг эзэмшиж буй гол хувьцаа эзэмшигчдийн жагсаалт /консорциумаар оролцож байгаа тохиолдолд энэхүү мэдээллийг консорциумын гишүүн тус бүрээр гаргаж өгнө/,

- Тендерт консорциумын хэлбэрээр оролцох тохиолдолд консорциумын гишүүдийн хооронд байгуулсан гэрээ, гаргасан шийдвэрийн баталгаа.

Өргөдөл болон нууцыг хадгалах тухай гэрээний загварыг интернет дахь Төрийн өмчийн хорооны **www.spc.gov.mn** вэб хуудаснаас буюу энэхүү зар мэдээний ард бичигдсэн хаягаар авч болно. Тендерийн хураамжийг Төрийн өмчийн хорооны дараах дансанд төлнө.

| | |
|---|---|
| Банкны нэр: | Монгол Улсын "Монголбанк" |
| SWIFT код: | BOMUMNUB |
| Дансны нэр: | Төрийн өмчийн хороо |
| Дансны дугаар: | 3332404 |
| Монголбанкны харилцагч банк: | Federal Reserve Bank of New York, NY, USA |
| SWIFT код: | FRNYUS33 |
| Дансны нэр: | Монголбанк |
| Дансны дугаар: | 021088506 |

Тендерт оролцогч тендерт өөрийгөө төлөөлүүлэн оролцуулахаар итгэмжлэгдсэн төлөөлөгч томилж, төлөөлөх эрхийг зохих журмын дагуу бичгээр үйлдсэн итгэмжлэлээр баталгаажуулна. Тендерт хэд хэдэн хуулийн этгээд хамтарч консорциумын хэлбэрээр оролцож байгаа бол тэд зөвхөн нэг итгэмжлэгдсэн төлөөлөгчийг томилж, тендерт нэг оролцогч болж оролцоно.

Тендерт оролцох хүсэлтээ илэрхийлсэн өргөдлийг 2003 оны 9 дүгээр сарын 16-ны өдрийн (Улаанбаатарын цагаар) 18.00 цагаас өмнө ТӨХ-нд ирүүлнэ.

Урьдчилан шалгаруулах шалгуур

Өргөдөл гаргагч нь тендерт оролцох эрхтэй болж, тендерийн баримт бичгүүдийг хүлээж авахын тулд оёмол, сүлжмэл эдлэл, бэлэн хувцасны үйлдвэрлэл эрхэлдэг хөрөнгө оруулагч, тэдгээрийн оролцоотой консорциум, оёмол, сүлжмэл эдлэл, бэлэн хувцасны салбарын техникийн түнш болон/буюу менежментийн багийг хоёроос (2) доошгүй жил гэрээгээр ажиллуулах үүрэг хүлээх чадвартай санхүүгийн хөрөнгө оруулагч зэрэг шаардлага хангасан хөрөнгө оруулагчид байхын зэрэгцээ дор дурдсан шаардлагыг хангасан байвал зохино. Үүнд:

1. Оёмол, сүлжмэл эдлэл, бэлэн хувцасны үйлдвэрлэлийн салбарт тав (5)-аас доошгүй жил үйл ажиллагаа явуулсан туршлагатай байх, эсвэл оёмол, сүлжмэл, эдлэл, бэлэн хувцасны үйлдвэрлэлийн салбарт тав (5)-аас доошгүй жил үйл ажиллагаа явуулсан туршлагатай техникийн түнш болон/буюу менежментийн багийг хоёр (2)-оос доошгүй жил гэрээгээр ажиллуулах үүрэг хүлээх чадвартай байх,

2. Санхүүгийн байдал нь тогтвортой, үйл ажиллагааны баялаг туршлагатай байх / үүнийг аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан тэнцлээр нотолно/,

3. Хувийн өмчийн хяналттай, гучин (30) хувиас дээшгүй төрийн өмчийн оролцоотой этгээд байх,

**Монголын болон гадаад улсын дор дурдсан хуулийн этгээд тендерт оролцохыг хориглоно:**

1. төрийн байгууллага,
2. төрийн өмчит үйлдвэрийн газар,
3. улсын төсвөөс санхүүждэг албан газар, төрийн бус байгууллага,
4. гучин (30) хувиас дээш төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж.

30-аас дээш хувийн Засгийн газрын эх үүсвэр бүхий хөрөнгийг удирддаг хөрөнгө оруулалтын компанийг тендерт оролцуулах асуудлыг ТӨХ тухай бүр шийдвэрлэнэ.

**Урьдчилан шалгаруулалтын үр дүнг мэдээлэх**

ТӨХ өргөдөл хүлээн авснаас хойш ажлын 10 /арван/ хоногийн дотор урьдчилан шалгаруулалтын шалгуурыг хангаж тендерт оролцох эрхтэй болж, тендерийн баримт бичгүүдийг авах болсон эсэх талаар өргөдөл гаргагчид мэдэгдэнэ. Энэхүү мэдэгдлийг бичгээр үйлдэн буухиа шуудан, баталгаат захиа, факс буюу электрон шуудангаар явуулна.

Урьдчилан шалгаруулалтын шалгуурыг хангасан тендерт оролцогчдод мэдэгдлийг тендерийн баримт бичгийн хамт буухиа шуудангаар хүргүүлнэ.

Тендерийн баримт бичгүүд

Тендерийн баримт бичиг гадэгт дараахь иж бүрдлийг ойлгоно:

1) Ерөнхий мэдээлэл,
2) Уралдаант шалгаруулалт /тендер/-ын журам,
3) Хувьцаа худалдах, худалдан авах тухай гэрээний төсөл.

**Хувьчлалын зорилго**

"Говь" ХК-ийн нийт хувьцааны төрийн эзэмшлийн 70 хувийг худалдаж авах сонирхолтой стратегийн хөрөнгө оруулагчид Засгийн газраас дэвшүүлж буй доор дурдсан хувьчлалын зорилгыг хангах бизнесийн стратеги болон үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж, тендерийн саналтай хамт ирүүлэх шаардлагатай. Үүнд:

- Худалдан авагч нь компанийн бизнесийн үндсэн чиглэл, Монгол Улсын ноос, ноолууран бүтээгдэхүүний тэргүүний үйлдвэрлэгч болохын хувьд урьд өмнө зах зээлд эзэлж байсан байр суурийг хадгалах, сайжруулах;
- Худалдан авагч нь "Говь" ХК-ийн боловсруулах үйлдвэрийг шинэчлэх ба өргөтгөх зорилгоор хөрөнгө оруулалт хийх;
- Боловсруулалтын түвшин болон экспортын хэмжээг нэмэгдүүлэх замаар компанийн өндөр үнэ цэнэтэй, дээд зэрэглэлийн эцсийн бүтээгдэхүүний зах зээлийг өргөтгөх;
- Монголын ноолуурын үйлдвэрлэлийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, тогтвортой хөгжлийг хангах зорилгоор орчин үеийн удирдлага болон технологийн ноу-хау нэвтрүүлэх.

**Тендерийн ажиллагаа**

Тендерт оролцогчид техникийн болон санхүүгийн саналаас бүрдэх тендерийн саналаа тендерийн дэнчин төлснийг нотлох баримтын хамт 2003 оны 12 дугаар сарын 9-ний өдрийн (Улаанбаатарын цагаар) 18.00 цагаас өмнө Төрийн өмчийн хороонд ирүүлнэ.

***"Дэнчин"*** гэж хувьцаа худалдах, худалдан авах тухай гэрээг дуусгавар болох үүрэг хүлээж буйгаа болон санхүүгийн эх үүсвэртэй болохоо батлан тендерт оролцогчоос төлөх 100000 /нэг зуун мянган/ ам. доллартай тэнцэх хүүгүй мөнгөн хадгаламжийг хэлнэ. Тендерт оролцогчид дэнчинг Монгол Улсын "Монголбанк" дахь ТӨХ-ны 3332404 дугаартай валютын дансанд төлнө.

Тендерийн саналыг үнэлсний дараа, тендерт оролцогч ялагчаар шалгараагүй тохиолдолд тендерийн дэнчинг тендерт оролцогчийн хүсэлтийн дагуу ажлын долоон /7/ өдөрт багтаан бүрэн буцаан олгох бөгөөд хүсэлтэд дэнчинг шилжүүлэх банкны дансны дугаарыг тодорхой заана.

Ялагчаар шалгарсан тендерт оролцогчийн дэнчинг худалдан авах үнэд оролцуулан тооцно.

Тендерийн саналаа бэлтгэхэд нь туслах зорилгоор тендерт оролцогчдыг Засгийн газрын холбогдох албан тушаалтан болон компанийн удирдлагатай уулзах, компанитай газар дээр нь танилцах, дүн шинжилгээ хийх боломжоор хангана. Тендерт оролцогчдыг хувьцаа худалдах, худалдан авах тухай гэрээний төсөлд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай санал гаргах боломжоор хангана.

**Тендерийн саналыг** дараахь байдлаар үнэлнэ:

1. Хөрөнгө оруулагчийн нэр хүнд, бизнесийн чадавхи, санхүүгийн байдал, салбарын туршлага (0-40 оноо),

2. Санал болгож буй бизнесийн стратеги/үйл ажиллагааны төлөвлөгөөний чанар, Засгийн газраас дэвшүүлж буй хувьчлалын зорилгыг хүлээн авч тусгасан байдал (0-60 оноо).

Дэд үзүүлэлт:

- Бизнесийн стратеги, үйл ажиллагааны төлөвлөгөөний цар хүрээ, тодорхой байдал (0-10 оноо),
  Төлөвлөгөө, стратеги нь Засгийн газраас дэвшүүлэх хувьчлалын зорилгод нийцсэн байдал (0-20 оноо),
- Компанийн техник, тоног төхөөрөмжийн хүчин чадлыг шинэчлэх, өртөг зардлын тооцоо, хэрэгжүүлэх хугацааны хуваарь бүхий техникийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөө (0-10 оноо),

- Байгаль орчинд харш нөлөө үзүүлэхгүй бизнесийн үйл ажиллагаа явуулах төлөвлөгөө (0-10 оноо),
- Хүний нөөцийг хөгжүүлэх төлөвлөгөө, ажиллагсдыг сургах зэрэг хүний хүчин зүйлийг хөгжүүлэхэд оруулах хөрөнгө оруулалтын цар хүрээ, шинж чанар (0-10 оноо).

Техникийн үнэлгээгээр 70-аас доошгүй оноо авсан саналыг шалгаруулна.

**Санхүүгийн санал** нь тендерээр худалдаалагдаж буй компанийн төрийн эзэмшлийн хувьцааг худалдан авахаар тендерт оролцогчоос санал болгож буй үнээс бүрдэнэ. Компанийн төрийн эзэмшлийн 70 хувийн хувьцааг худалдан авахаар санал болгох үнэ нь 11.6 (арван нэгэн сая зургаан зуун мянга) сая ам. доллараас доошгүй байна.

Техникийн үнэлгээгээр авбал зохих доод онооны болзлыг хангаж тэнцсэн, санхүүгийн саналдаа худалдан авах хамгийн өндөр үнийн саналыг ирүүлсэн оролцогчийг тендерийн ялагчаар шалгаруулна.

**"Говь" хувьцаат компанийн тухай**

"Говь" компанийн үйлдвэр нь Японы эдийн засаг, техникийн тусламжтайгаар 1981 онд ашиглалтад орсон.

1993 онд "Говь" компани нь 100.00 төгрөгийн нэг бүрийн нэрлэсэн үнэтэй 7,801,125 ширхэг хувьцаанаас бүрдсэн хувьцаат компани болж өөрчлөн байгуулагджээ. Үүнээс 5,843,681 ширхэг буюу нийт хувьцааны 74.9 хувийг Засгийн газар эзэмшиж байна. Нийт хувьцааны 25.1 хувь буюу үлдэх 1,957,444 ширхэг хувьцааг хувьчилсан бөгөөд Монголын хөрөнгийн биржээр арилжаалагдаж байна. Нэгж хувьцааны жилийн дундаж үнэ нь 2002 онд 1,196 төгрөг байв.

"Говь" компани нь самнасан ноолуур, ноолууран бэлэн сүлжмэл, нэхмэл, зэрмэл бүтээгдэхүүн үйлдвэрлэн борлуулахаас гадна тэмээний ноос, сарлагийн хөөвөр боловсруулдаг. Жилдээ 1,000 тонн түүхий ноолуур, ноос боловсруулж, 68 тонн бөмбөгөн ноолуур, 210 тонн самнасан ноолуур, 350,000 ширхэг сүлжмэл болон 153,000 уртааш метр нэхмэл бүтээгдэхүүн үйлдвэрлэх хүчин чадалтай.

"Говь" компани нийт 1,853 орчим ажилчинтай.

Компани нь дэлхийн өндөр чанартай түүхий ноолуур бэлтгэдэг 2 дахь томоохон зах зээлд оршдог. Дэлхийн нийт түүхий ноолуурын 21%-ийг Монгол, үлдэх хэсгийг БНХАУ (67%), Иран, Афганистан, Албани, ОХУ зэрэг орнуудад бэлтгэдэг юм. Компани нь ноолуурыг малчдын гар дээрээс шууд худалдан авдаг, Монголын орон нутагт тархан байрлах 11 төлөөлөгчийн газар бүхий өргөн сүлжээтэй. Компани 2002 онд 362.8 тонн түүхий эд бэлтгэснээс 219.4 тонн нь ноолуур, 132.6 тонн нь тэмээний ноос, 10.9 тонн нь нарийн хонины ноос, 0.1 тонн сарлагийн хөөвөр байв.

Компани нь Улаанбаатар хотод байрладаг. Нийслэлийн газрын албатай байгуулсан газар ашиглах тухай гэрээний дагуу компани нийт 129,316 квадрат метр газрыг ашиглаж, газар ашигласны түрээсийн төлбөрт жилдээ 9,244,488 төгрөг төлдөг.

Ноолуурын үйлдвэрлэл нь дараахь шат дамжлагуудаас бүрдэнэ:

- Анхан шатны боловсруулалт - ангилан ялгах, угаах, хялгас ялгах
- Будүүн ээрмэлийн шугам - будах, холих, аппарат самнах, ээрэх, эрчлэх, ороох
- Нарийн ээрмэлийн шугам - хувинт самнах, туузлах, нарийн зүүн самнах, нарийсган сунгах, нарийн самнах, ээрэх, эрчлэх, ороох
- Бэлэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх - сүлжих, оёх, нэхэх, эцсийн боловсруулалт хийх

Компани нь үйлдвэрийн шат дамжлагуудын ажиллагаа, тэдгээрээс гарах бүтээгдэхүүнийг хянах 3 лабораторитой бөгөөд 1995 оноос ISO-9000 чанарын стандартыг нэвтрүүлж итгэмжлэгдсэн лабораторийн эрх авсан.

Компани нь бүтээгдэхүүнээ Европ, Ази, Хойд Америкийн 30 орны 130 орчим компаниудад борлуулдаг. 2002 оны байдлаар нийт экспортын 88.7 хувийг Их Британи, Япон, Франц, Итали, Бельги, Герман, АНУ зэрэг улсуудад нийлүүлсэн. Компанийн экспортын гол бүтээгдэхүүн нь самнасан ноолуур, бөмбөгөн ноолуур болон ноолууран сүлжмэл эдлэл юм. Эдгээр бүтээгдэхүүн нь компанийн 2002 оны нийт экспортын 97.5%-ийг эзэлж байжээ. Экспортын үлдсэн хэсгийг нэхмэл ба оёмол эдлэл, ээрмэл голлон бүрдүүлж байна.

1997 онд Бельги улсын United cashmere S.P.A-тай хамтран байгуулсан "Говь-Европ" компанийн 75 %-ийг "Говь" компани эзэмшдэг (2003 оноос 100 хувь эзэмшдэг). Мөн 1998 онд "Говь-АНУ" компанийг АНУ-д байгуулсан байна.

2002 оны тайлан тэнцлийн үзүүлэлтээр компани нь нийт 18.5 сая ам. долларын борлуулалт хийжээ.

## Санхүүгийн тайлан тэнцлийн үзүүлэлтүүд:

### БАЛАНС
(мян.төгрөгөөр)

| 12 дугаар сарын 31-ний байдлаар | 2000 | 2001 | 2002 |
|---|---|---|---|
| **Эргэлтийн хөрөнгө** | | | |
| Мөнгөн хөрөнгө | 1 557 737 | 134 561 | 186 286 |
| Авлага | 3 317 197 | 3 567 410 | 3 932 004 |
| Бараа материал | 12 878 018 | 27 852 926 | 20 317 840 |
| Урьдчилан төлөгдсөн зардал | 387 504 | 60 324 | 27 49 |
| **Эргэлтийн хөрөнгийн дүн** | **18 140 456** | **31 615 221** | **24 463 625** |
| **Эргэлтийн бус хөрөнгө** | | | |
| Үндсэн хөрөнгө | 14 726 140 | 14 774 311 | 13 083 619 |
| Хөрөнгө оруулалт | 896 908 | 445 316 | 483 512 |
| Биет бус хөрөнгө | 36 295 | | |
| **Эргэлтийн бус хөрөнгийн дүн** | **15 659 342** | **15 219 627** | **13 567 132** |
| **Нийт хөрөнгө** | **33 799 798** | **46 834 848** | **38 030 757** |
| **Богино хугацаат өр төлбөр** | | | |
| Өглөг | 448 357 | 5 638 023 | 3 386 976 |
| Богино хугацаат зээлийн өглөг | - | 10 305 912 | 8 992 813 |
| Ногдол ашгийн өглөг | 179 489 | 191 488 | 169 965 |
| **Богино хугацаат өр төлбөрийн дүн** | **627 846** | **16 135 423** | **12 549 755** |
| **Урт хугацаат өр төлбөр** | - | **2 799 284** | - |
| **Өр төлбөрийн дүн** | **627 846** | **18 934 707** | **12 549 755** |
| **Эзэмшигчийн өмч** | | | |
| Хувьцаат капитал | 780 113 | 780 113 | 780 113 |
| Дахин үнэлгээний зөрүү | 9 169 679 | 9 478 843 | 9 383 387 |
| Хуримтлагдсан ашиг | 23 222 161 | 17 641 186 | 15 317 502 |
| **Эзэмшигчийн өмчийн дүн** | **33 171 952** | **27 900 141** | **25 481 002** |
| **Өр төлбөр ба эзэмшигчдийн өмчийн дүн** | **33 799 798** | **46 834 848** | **38 030 757** |

### ОРЛОГО, ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН
(мян. төгрөгөөр)

| 12 дугаар сарын 31-ний байдлаар | 2000 | 2001 | 2002 |
|---|---|---|---|
| **Борлуулалтын орлого** | **21 922 279** | **12 284 983** | **20 397 063** |
| Борлуулсан бүтээгдэхүүний өртөг | 17 050 609 | 9 469 757 | 19 468 808 |
| **Нийт ашиг** | **4 871 671** | **2 815 226** | **928 254** |
| Үйл ажиллагааны зардал | 988 696 | 4 504 659 | 600 232 |
| Бусад орлого | - | - | - |
| **Үйл ажиллагааны ашиг (алдагдал)** | **3 882 975** | **(1 689 433)** | **328 022** |
| Үйл ажиллагааны бус орлого | 1 477 336 | 751 865 | 542 426 |
| Үйл ажиллагааны бус зардал | 1 132 599 | 3 745 411 | 2 530 234 |
| **Татвар төлөхийн өмнөх ашиг** | **4 227 712** | **(4 682 978)** | **(1 659 785)** |
| Орлогын татвар | 1 666 085 | 188 488 | - |
| **Цэвэр ашиг** | **2 561 627** | **(4 871 466)** | **(1 659 785)** |

Тендерт оролцох өргөдөл, тендерийн саналыг дор дурдсан хаягаар ТӨХ-нд ирүүлнэ.

Л. Пүрэвдорж
Төрийн өмчийн хорооны дарга
Засгийн газрын 4-р байр, 410-р өрөө
Улаанбаатар-11, Монгол Улс
Утас: 976-11-312460
Факс: 976-11-312798

Нэмэлт мэдээлэл авах эсвэл тодруулах зүйл байвал Төрийн өмчийн хорооны дээрх хаягаар эсвэл ТӨХ-ны зөвлөх Бэринг Пойнт ХХК-ийн Барентс бүлгийн дор дурдсан хүмүүстэй холбоо барина уу.

Ч. Сайнжаргал
Э-шуудан: sainaa@mongol.net

Тереза Фабиано
Э-шуудан: tslazas@bearingpoint.net
tfabiano@bearingpoint.net

Живко Ненов
Э-шуудан: znenov@magicnet.mn

**Хаяг:**
Бэринг Пойнт ХХК-ийн Барентс бүлэг
Засгийн газрын 11-р байр, 301-р өрөө
Улаанбаатар-38
Монгол Улс
Утас: 976-11-324149
Факс: 976-11-324149
Э-шуудан: barents@magicnet.mn

Эсхүл
Тереза Фабиано
Barents Group of Bearing Point, Inc.
1676 International Drive
McLean, VA 22102, USA
Tel: +1 703-747-7698
Fax: +1 703-747-3919
E-mail: tslazas@bearingpoint.net
tfabiano@bearingpoint.net

Компанитай холбоотой мэдээлэл болон зарлалыг http://www.spc.gov.mn вэбсайтаас үзнэ үү.

*Засгийн газрын 2003 оны 131 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралт*

### УРАЛДААНТ ШАЛГАРУУЛАЛТ /ТЕНДЕР/-ЫН ЖУРАМ

## 1. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Монгол Улсын Иргэний хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Монгол Улсын Их Хурлын 2001 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 10 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн өмчийг 2001-2004 онд хувьчлах үндсэн чиглэл", Засгийн газрын 2003 оны 1 дүгээр сарын 22-ны өдрийн 14 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрийн өмчийг 2003 онд хувьчлах хөтөлбөр"-ийн дагуу "Говь" ХК-ийн нийт хувьцааны төрийн эзэмшлийн 70 хувьд ногдох 5460788 (таван сая дөрвөн зуун жаран мянга долоон зуун наян найм) ширхэг энгийн хувьцааг хаалттай уралдаант шалгаруулалт /тендер/-ын аргаар гадаадын буюу дотоодын стратегийн хөрөнгө оруулагчдад худалдахад энэхүү журам /цаашид "журам" гэх/-ыг мөрдөнө.

1.2. Төрийн өмчийн хороо нь зөвлөхүүдийн туслалцаатайгаар тендерийг зохион байгуулж явуулна.

## 2. НЭР ТОМЪЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ

Энэхүү журамд хэрэглэсэн нэр томъёог дор дурдсанаар тодорхойлно:

*2.1. "Компани"* гэж "Говь" ХК-ийг хэлнэ.

*2.2. "Стратегийн хөрөнгө оруулагч"* гэж оёмол, сүлжмэл эдлэл, бэлэн хувцасны үйлдвэрлэл эрхэлдэг хөрөнгө оруулагч, тэдгээрийн оролцоотой консорциум, оёмол, сүлжмэл эдлэл, бэлэн хувцасны салбарын техникийн түнш болон/буюу менежментийн багийг хоёр /2/-оос доошгүй жил гэрээгээр ажиллуулах үүрэг хүлээх чадвартай санхүүгийн хөрөнгө оруулагч зэрэг шаардлага хангасан хөрөнгө оруулагчийг хэлэх бөгөөд эдгээр нь дор дурдсан шаардлагыг хангасан байвал зохино. Үүнд:

(а) Оёмол, сүлжмэл эдлэл, бэлэн хувцасны үйлдвэрлэлийн салбарт тав (5)-аас доошгүй жил үйл ажиллагаа явуулсан туршлагатай байх, эсвэл оёмол, сүлжмэл эдлэл, бэлэн хувцасны үйлдвэрлэлийн салбарт тав (5)-аас доошгүй жил үйл ажиллагаа явуулсан туршлагатай техникийн түнш болон/буюу менежментийн багийг хоёр (2)-оос доошгүй жил гэрээгээр ажиллуулах үүрэг хүлээх чадвартай байх,

(б) Санхүүгийн байдал нь тогтвортой, үйл ажиллагааны баялаг туршлагатай байх / үүнийг аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан тэнцлээр нотлоно/.

*2.3. "Ерөнхий мэдээлэл"* гэж тендерт оролцогч тус бүрт хүргэх "Говь" ХК болон Монгол Улс, түүний бизнесийн орчны талаархи мэдээлэл бүхий баримт бичгийг хэлнэ.

*2.4. "Дэнчин"* гэж хувьцаа худалдах, худалдан авах тухай гэрээг дуусгавар болох үүрэг хүлээж буйгаа болон санхүүгийн эх үүсвэртэй болохоо батлан тендерт оролцогчоос төлөх 100,000 /нэг зуун мянган/ ам. доллартай тэнцэх хүүгүй мөнгөн хадгаламжийг хэлнэ. Дэнчинг Монгол Улсын Монголбанк дахь Төрийн өмчийн хорооны валютын дансанд төлнө.

*2.5. "Зар мэдээ"* гэж Төрийн өмчийн хорооноос тендер явуулах тухай нийтэд сонордуулсан албан ёсны зар мэдээг хэлнэ.

*2.6. "Зөвлөх"* гэж Америкийн Нэгдсэн Улсын Олон улсын хөгжлийн агентлагийн тусламжтайгаар Төрийн өмчийн хороонд зөвлөх үйлчилгээ үзүүлж буй Бэринг Пойнт ХХК-ийн Барентс бүлгийн зөвлөхүүдийг хэлнэ.

*2.7. "Нууцыг хадгалах тухай гэрээ"* гэж компани, Төрийн өмчийн хороо, Монгол Улсын Засгийн газар болон зөвлөхүүдээс өгөх компанитай холбоотой аливаа мэдээллийг ямар нэгэн хэлбэрээр тараах болон мэдээлэхийг хориглосон гэрээг хэлнэ.

*2.8. "Өргөдөл"* гэдэгт тендерт оролцогчоос ирүүлэх өргөдөл, өргөдөл гаргагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч гарын үсэг зурсан нууцыг хадгалах тухай гэрээ болон тендерийн хураамж төлснийг нотлох баримтын иж бүрдлийг ойлгоно. Итгэмжлэгдсэн төлөөлөгчийн төлөөлөх эрхийг зохих журмын дагуу бичгээр үйлдэж өргөдөлд хавсаргасан итгэмжлэлээр баталгаажуулна. Өргөдөл гаргагч тендерийн оролцогч болохын тулд урьдчилан шалгаруулалтад шаардагдах өөрийн компанийн болон консорциумын талаархи тусгай мэдээллийг өргөдөлд хавсаргасан байна.

*2.9. "Тендерийн баримт бичиг"* гэдэгт:
1) Уралдаант шалгаруулалт /тендер/-ын журам,
2) Ерөнхий мэдээлэл,
3) Хувьцаа худалдах, худалдан авах тухай гэрээний төслийн иж бүрдлийг ойлгоно.

*2.10. "Тендерт оролцогч"* гэж тендерт оролцохоор өргөдөл гаргаж, урьдчилан шалгаруулалтын шаардлагыг хангаж, Төрийн өмчийн хороо өргөдлийг нь хүлээн авсан хуулийн этгээд буюу тэдгээрийн хамтарсан консорциумыг хэлнэ.

*2.11. "Тендерийн санал"* гэж тендерт оролцогчоос уралдаант шалгаруулалтад оролцохоор ирүүлсэн саналыг хэлнэ. Тендерийн санал нь техникийн ба санхүүгийн саналаас бүрдсэн байна.

*2.12."Тендерийн хураамж"* гэж тендерийн баримт бичгээр хангах үйлчилгээний хураамж болгон тендерт оролцогчоос Төрийн өмчийн хороонд төлөх 1,000 /нэг мянган/ ам. долларын буцааж төлөгдөхгүй нөхцөлтэй төлбөрийг хэлнэ.

*2.13. Уралдаант шалгаруулалт* /цаашид *"тендер"* гэх/ гэж тендерт оролцогчдоос ирүүлсэн тендерийн саналуудыг хянан үзэж, ялагчийг тодруулан, түүнтэй хувьцаа худалдах, худалдан авах тухай гэрээ байгуулах үйл ажиллагааг хэлнэ.

*2.14. "Хувьцаа худалдах, худалдан авах тухай гэрээний төсөл"* гэж Төрийн өмчийн

хорооноос санал болгож буй, тендерт оролцогчдын саналыг авахаар хүргүүлэх хувьцаа худалдах, худалдан авах гэрээний төслийн эхний хувилбарыг хэлнэ.

***2.15. "Хувьцаа худалдах, худалдан авах тухай гэрээний шинэчилсэн төсөл"*** гэж хувьцаа худалдах, худалдан авах тухай гэрээний төслийн эхний хувилбарт тендерт оролцогчдын өгсөн саналыг тусгасан шинэчилсэн хувилбарыг хэлнэ.

***2.16 "Хувьцаа худалдах, худалдан авах тухай гэрээний эцсийн төсөл"*** гэж хувьцаа худалдах, худалдан авах тухай гэрээний шинэчилсэн төсөлд тендерт оролцогчдоос санал болгосон нэмэлт, өөрчлөлтөөс хүлээн авч болохуйц саналуудыг тусган Төрийн өмчийн хорооноос эцэслэн бэлтгэж гаргах төслийг хэлнэ.

***2.17. "Худалдан авах үнэ"*** гэж тендерээр худалдаалагдаж буй компанийн хувьцааг худалдан авахаар тендерт оролцогчоос санал болгож буй үнийн дүнг хэлнэ.

### 3. ТЕНДЕРИЙН ХУВААРЬ

3.1. Тендерийг энэхүү журамд хавсаргасан хуваарийн дагуу зохион байгуулж явуулна. / Хавсралт 1/

### 4. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧ

**4.1. Тендерт оролцогчийн эрх зүйн байдал**

4.1.1. Урьдчилан шалгаруулалтад тэнцсэн, Монголын болон гадаад улсын дор дурдсанаас бусад бүх боломжит хуулийн этгээд тендерт оролцож болно:

1) Төрийн байгууллага;
2) Төрийн өмчит үйлдвэрийн газар;
3) Улсын төсвөөс санхүүждэг албан газар, төрийн бус байгууллага;
4) Гучин (30) хувиас дээш төрийн өмчийн оролцоотой аж ауйн нэгж.

4.1.2. Хуулийн этгээд дангаараа эсвэл хамтарч консорциумын хэлбэрээр тендерт оролцож болно.

4.1.3. Тендерт оролцогч тендерт өөрийгөө төлөөлүүлэн оролцуулахаар итгэмжлэгдсэн төлөөлөгч томилж, төлөөлөх эрхийг зохих журмын дагуу бичгээр үйлдсэн итгэмжлэлээр баталгаажуулна.

4.1.4. Тендерт хэд хэдэн хуулийн этгээд хамтарч консорциумын хэлбэрээр оролцож байгаа бол тэд зөвхөн нэг /1/ итгэмжлэгдсэн төлөөлөгчийг томилж, тендерт нэг оролцогч болж оролцоно.

4.1.5. 30-аас дээш хувийн Засгийн газрын эх үүсвэр бүхий хөрөнгийг удирддаг хөрөнгө оруулалтын компанийг тендерт оролцуулах асуудлыг ТӨХ тухай бүр шийдвэрлэнэ.

**4.2. Тендерт оролцогчийн эрх**

4.2.1.Тендерт оролцогч нь тендерт оролцох өргөдлөө ирүүлж, урьдчилан шалгаруулалтад тэнцсэн тохиолдолд Төрийн өмчийн хорооноос баталж, тэмдэг дарсан тендерийн баримт бичгийн нэг иж бүрэн багцыг авах эрхээр хангагдана.

4.2.2. Тендерт оролцогчид дараахь эрх эдэлнэ:

1. Төрийн өмчийн хорооноос баталж гаргасан компанитай танилцах, дүн шинжилгээ, уулзалт хийх хуваарийн дагуу компанийн удирдлагатай уулзах, барилга байгууламжийг үзэх,

2. Төрийн өмчийн хорооноос бичгээр зөвшөөрөл авсны үндсэн дээр Монгол Улсын Засгийн газрын холбогдох албан тушаалтантай уулзах,

3. Энэхүү журам болон тендерийн үйл ажиллагаатай холбогдсон мэдээллийн талаар тайлбар авах зорилгоор тус компанийн хувьчлалын асуудлыг хариуцсан Төрийн өмчийн хорооны итгэмжлэгдсэн төлөөлөгчтэй уулзах.

Тайлбар авах хүсэлтийг англи буюу монгол хэл дээр үйлдэж Төрийн өмчийн хороонд дараахь хаягаар бичгээр ирүүлнэ.

Л. Пүрэвдорж
Төрийн өмчийн хорооны дарга
Засгийн газрын IV байр, 410-р өрөө
Улаанбаатар-11, Монгол Улс
Утас: 976-11-312460
Факс: 976-11-312798

Төрийн өмчийн хороо ирсэн бүх хүсэлтэд бичгээр хариулт өгөх бөгөөд асуулт, хариултын хувийг тендерт оролцогч бүрт тэдний өргөдөл дээр заасан хаягаар хүргүүлнэ. Ийнхүү хүргүүлэхдээ буухиа шуудан, баталгаат шуудан, факс эсвэл электрон шууданг ашиглана.

Тендерийн санал авах хугацаа дуусахаас өмнөх ажлын тав /5/ хоногоос хожимдуулж ирүүлсэн тайлбар авах хүсэлтийг Төрийн өмчийн хороо хүлээж авахгүй байж болно.

4. Монгол Улсын "Иргэний хууль", "Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль"-д заасан бусад эрх эдлэх.

**4.3. Тендерт оролцогчийн үүрэг**

Тендерт оролцогч нь дараахь үүрэгтэй:

4.3.1. Өөрийн бизнес, эрх зүй, санхүүгийн байдлын талаар үнэн зөв мэдээлэл өгөх;

4.3.2. Тендерт оролцох явцад өөрийн бизнес, эрх зүй, санхүүгийн байдалд гарсан, тендерт оролцоход нь нөлөөлж болзошгүй аливаа материаллаг өөрчлөлтийн талаар Төрийн өмчийн хороонд нэн даруй мэдээлэх;

4.3.3. Компанийн хувьцааг худалдан авах талаар тендерийн бусад оролцогчидтой ямар нэгэн харилцаа холбоо тогтоох болон аливаа хэлбэрээр хэлэлцээрт орохгүй байх;

4.3.4. Компанитай байгуулсан буюу байгуулахаар төлөвлөж байгаа бизнесийн аливаа гэрээ, хэлэлцээрийн талаар Төрийн өмчийн хороонд бичгээр мэдэгдэх;

4.3.5. Тендерт оролцох буюу оролцохтой холбогдон гарах бүх зардлыг өөрөө хариуцах;

4.3.6. Монгол Улсын хууль тогтоомж болон энэхүү журмыг сахин биелүүлэх.

## 5. ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ

5.1. Тендерт оролцогч тус бүрт тендерийн баримт бичгийн нэг иж бүрэн багцыг олгоно.

5.2. Төрийн өмчийн хорооноос олгох тендерийн баримт бичигт Төрийн өмчийн хорооны тэмдэг дарсан байна.

5.3. Төрийн өмчийн хороо болон зөвлөхүүд тендертэй холбоотой мэдээллийг тендерийн баримт бичигт оруулна. Энэхүү мэдээллийг ашиглахтай холбоотойгоор үүсч болох аливаа үүрэг, хариуцлагыг Төрийн өмчийн хороо болон зөвлөхүүдийн аль аль нь хүлээхгүй.

## 6. ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙХ

6.1. Тендерт оролцогчдыг тэдгээрийн хүсэлтийн дагуу Засгийн газрын холбогдох албан тушаалтан болон компанийн удирдлагатай уулзах, компанитай газар дээр нь танилцах боломжоор хангана.

6.2. Тендерт оролцогчдод тендерийн саналаа ирүүлэхээс өмнө компани дээр очиж компанийн хөрөнгө, өр төлбөрийн талаар нарийвчилсан дүн шинжилгээ хийх, өөрсдийн саналаа хэлэх, Засгийн газраас дэвшүүлж буй хувьчлалын зорилгын талаар Төрийн өмчийн хорооны ажилтнуудтай болон зөвлөхүүдтэй ярилцах боломжоор олгоно. Төрийн өмчийн хороо тендерт оролцогч тус бүрт 2 /хоёр/ долоо хоног хүртэл хугацаагаар компани дээр очиж түүний үйл ажиллагаанд нарийвчилсан дүн шинжилгээ хийх хуваарь гаргах ба оролцогч хүсэлт гаргасан тохиолдолд Төрийн өмчийн хороо өөрийн үзэмжээр нэмэлт хугацаа олгоно. Дүн шинжилгээний хугацаанд тендерт оролцогчид компанийн удирдлага, ажилтнуудтай уулзах өргөн боломжоор хангагдах бөгөөд компанийн бүртгэл, баримт, түүнчлэн компьютерийн систем, конторын болон бусад барилга байгууламжийн байдал болон өөрсдийн сонирхсон хүрээнд аливаа бусад асуудлыг судлах эрхээр хангагдана.

6.3. Төрийн өмчийн хороо компани дээр очиж дүн шинжилгээ хийх хуваарийг хүсэлт хүлээж авсан дараалаар гаргаж, тендерт оролцогчдод энэ тухай факс болон/буюу электрон шуудангаар мэдэгдэнэ.

6.4. Тендерт оролцогч нь тендерийн саналаа ирүүлснээр компанийн нөхцөл байдал, үйл ажиллагаатай танилцаж, улмаар эдгээрийг зөвшөөрч, Төрийн өмчийн хорооноос буюу түүний өмнөөс компанийн талаар гаргаж өгсөн бүх мэдээллийн үнэн зөв болохыг албан ёсоор хүлээн зөвшөөрсөнд тооцогдоно. Байгаа мэдээлэл, бодит байдалтай танилцаж чадаагүй тендерт оролцогч нь тендерийн санал, хувьцаа худалдах, худалдан авах тухай гэрээний төслийг боловсруулах үүргээс чөлөөлөгдөхгүй. Төрийн өмчийн хороо, түүний зөвлөх, компани, эдгээрийн төлөөлөгчдөөс гаргаж өгсөн мэдээлэлд үндэслэн тендерт оролцогчийн зүгээс гаргасан дүгнэлт, тайлбарын талаар Төрийн өмчийн хороо, түүний зөвлөх, шинжээчдийн баг, компани, эдгээрийн төлөөлөгчдийн аль аль нь хариуцлага хүлээхгүй.

6.5. Тендерт оролцогч компанитай танилцах, дүн шинжилгээ болон уулзалт хийхгүй байхаар шийдвэрлэсэн тохиолдолд ч тендерийн санал өгөх эрхтэй хэвээр үлдэнэ.

## 7. ХУВЬЦАА ХУДАЛДАХ, ХУДАЛДАН АВАХ ТУХАЙ ГЭРЭЭНИЙ ТӨСЛИЙГ ЭЦЭСЛЭН БОЛОВСРУУЛАХ

7.1. Тендерт оролцогчдоос санал болгож 2003 оны 10 дугаар сарын 14-ний дотор Төрийн өмчийн хороонд ирүүлсэн нэмэлт, өөрчлөлтүүд дээр үндэслэн Төрийн өмчийн хороо хувьцаа худалдах, худалдан авах тухай гэрээний төсөлд нэмэлт, өөрчлөлт оруулж, уг гэрээний шинэчилсэн төслийг боловсруулж болно.

7.2. Төрийн өмчийн хороо хувьцаа худалдах, худалдан авах тухай гэрээний шинэчилсэн төслийг боловсруулсан тохиолдолд энэ тухай тендерт оролцогч тус бүрт мэдэгдэж, шинэчилсэн төслийн хувийг 2003 оны 10 дугаар сарын 28-ны дотор тараана.

7.3. Тендерт оролцогчдод хувьцаа худалдах, худалдан авах тухай гэрээний шинэчилсэн төсөлд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай саналаа 2003 оны 11 дүгээр сарын 11-ний дотор ирүүлэхийг санал болгоно. Энэ өдрөөс хойш ирүүлсэн санал, тайлбарыг хүлээж авахгүй.

7.4. Тендерт оролцогчдоос хувьцаа худалдах, худалдан авах тухай гэрээний шинэчилсэн төсөлд оруулахаар санал болгосон нэмэлт, өөрчлөлтүүдийг үндэслэн Төрийн өмчийн хороо хувьцаа худалдах, худалдан авах тухай гэрээний эцсийн төслийг боловсруулж, тендерт оролцогч тус бүрт 2003 оны 11 дүгээр сарын 25-ны дотор тараана.

## 8. ТЕНДЕРИЙН САНАЛ БЭЛТГЭХ,САНАЛ ИРҮҮЛЭХЭД ТАВИГДАХ ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

8.1. Бүх мөнгөн дүнг Америкийн Нэгдсэн Улсын доллараар илэрхийлнэ.

8.2. Тендерт оролцогчид тендерийн саналын нэг /1/ эх хувь болон таван /5/ хуулбарыг ирүүлнэ.

8.3. Тендерт оролцогчид тендерийн саналыг англи буюу монгол хэлний аль нэг дээр бэлтгэж ирүүлнэ. Харин хувьцаа худалдах, худалдан авах гэрээний эцсийн төслийн гарын үсэг зурсан хоёр /2/ эх хувийг англи болон монгол хэл дээр бэлтгэж, техникийн саналын эх хувьд хавсарган ирүүлнэ.

8.4. Саналын эх хувь болон хуулбаруудын хооронд ямар нэгэн зөрүү гарах тохиолдолд эх хувийг баримтална.

8.5. Тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч тендерийн саналын эх хувьд хар буюу хөх енгийн бэхээр гарын үсэг зурж, хуудас бүрийг үзэглэнэ. Итгэмжлэгдсэн төлөөлөгчид олгосон эрхийг зохих журмын дагуу бичгээр үйлдэн, тендерийн саналд хавсаргасан итгэмжлэлээр баталгаажуулна.

8.6. Тендерийн саналд оруулсан бүх засварт тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч гарын үсгээ зурах буюу үсэглэж баталгаажуулна.

8.7. Тендерийн саналыг шуудангаар ирүүлсэн тохиолдолд Төрийн өмчийн хороон дээр хүлээн авсан өдрийг тендерийн санал ирүүлсэн өдөр гэж тооцно.

8.8. Төрийн өмчийн хороо тендерийн саналыг хүлээж авсан огноо, цагийг тэмдэглэсэн баримтыг оролцогч тус бүрт илгээж хүлээн авсныг батална. Шуудангаар ирүүлсэн тендерийн саналын дугтуйн дээр хариу илгээх факсын дугаарыг заагаагүй тохиолдолд хүлээн авсан тухай баримтыг дугтуйн дээрх хаягаар эсвэл тендерт оролцогчийн Төрийн өмчийн хорооны бүртгэлд тусгагдсан хаягаар илгээнэ.

8.9. Тендерт оролцогч нь тендерийн санал хүлээн авах хугацаа дуусахаас өмнө Төрийн өмчийн хороонд бичгээр мэдэгдэж, тендерийн саналаа өөрчлөх, эсвэл татан авах эрхтэй.

## 9. ДЭНЧИН

9.1. Тендерийн саналаа ирүүлэх хүсэлтэй тендерт оролцогчид Төрийн өмчийн хорооны дор дурдсан валютын харилцах дансанд 100,000 /нэг зуун мянган/ америк долларын дэнчин төлнө. Үүнд:

| | |
|---|---|
| Банкны нэр: | Монгол Улсын "Монголбанк" |
| SWIFT код: | BOMUMNUB |
| Дансны нэр: | Төрийн өмчийн хороо |
| Дансны дугаар: | 3332404 |
| Харилцагч банк: | Federal Reserve Bank of New York, NY, USA |
| SWIFT код: | FRNYUS33 |
| Дансны нэр: | Монголбанк |
| Дансны дугаар: | 021088506 |

Дэнчин төлснийг нотолсон банкны баримтын хуулбарыг техникийн саналд хавсаргана.

9.2. Тендерт оролцогч нь дэнчин тавиагүй тохиолдолд тендерт оролцох эрхгүй.

9.3. Тендерт ялагчаар шалгарсан оролцогчийн тавьсан дэнчинг худалдан авах үнэд оролцуулан тооцно.

9.4. Тендерийн саналыг үнэлсний дараа, тендерт оролцогч ялагчаар шалгараагүй тохиолдолд тендерийн дэнчинг тендерт оролцогчийн хүсэлтийн дагуу ажлын долоон /7/ өдөрт багтаан бүрэн буцаан олгох бөгөөд уг хүсэлтэд дэнчинг шилжүүлэх банкны дансны дугаарыг тодорхой заана.

9.5. Дэнчинг дараахь тохиолдолд буцааж олгохгүй:

1) Ялагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч хувьцаа худалдах, худалдан авах тухай гэрээ байгуулах үндэслэл болох тендерийн үр дүнгийн тухай мэдэгдэл /тэмдэглэл/-д гарын үсэг зурахаас татгалзсан,

2) Ялагч нь хувьцаа худалдах, худалдан авах тухай гэрээний нөхцөл, болзлын дагуу худалдан авах үнийн төлбөрийг хийгээгүй буюу хувьцаа худалдах, худалдан авах тухай гэрээнд заасан өөрийнхөө аливаа мэдэгдэл, баталгаа, тохиролцоогоо материаллаг байдлаар зөрчсөн.

9.6. Дэнчинд хүү төлөхгүй.

9.7. Дэнчин төлөхтэй холбогдсон банкны бүх зардлыг тендерт оролцогч хариуцна.

## 10. ТЕНДЕРИЙН САНАЛ БЭЛТГЭН ИРҮҮЛЭХ

10.1. "Говь" ХК-ийн нийт хувьцааны төрийн мэдлийн 70 хувийг худалдаж авах сонирхолтой стратегийн хөрөнгө оруулагчид Засгийн газраас дэвшүүлж буй дор дурдсан хувьчлалын зорилгыг хангах бизнесийн стратеги болон үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж, техникийн саналтай хамт ирүүлэх шаардлагатай. Үүнд:

- Худалдан авагч нь компанийн бизнесийн үндсэн чиглэл, Монгол Улсын ноос, ноолууран бүтээгдэхүүний тэргүүний үйлдвэрлэгч болохын хувьд урьд өмнө зах зээлд эзэлж байсан байр суурийг хадгалах, сайжруулах;
- Худалдан авагч нь "Говь" ХК-ийн боловсруулах үйлдвэрийг шинэчлэх ба өргөтгөх зорилгоор хөрөнгө оруулалт хийх;
- Боловсруулалтын түвшин болон экспортын хэмжээг нэмэгдүүлэх замаар компанийн өндөр үнэ цэнэтэй, дээд зэрэглэлийн эцсийн бүтээгдэхүүний зах зээлийг өргөтгөх;
- Монголын ноолуурын үйлдвэрлэлийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, тогтвортой хөгжлийг хангах зорилгоор орчин үеийн удирдлага болон технологийн ноу-хау нэвтрүүлэх.

**10.2. Тендерийн санал** дараахь хоёр хэсгээс бүрдэнэ. Үүнд:

- Техникийн санал /бизнесийн стратеги болон үйл ажиллагааны төлөвлөгөөний хамт/,
- Санхүүгийн санал.

10.3 **Техникийн болон санхүүгийн саналуудыг тус тусад нь битүүмжлэн дугтуйлж хүргүүлнэ**. Саналуудын эх хувь болон хуулбаруудыг "ЭХ ХУВЬ", "ХУУЛБАР", "ТЕХНИКИЙН САНАЛ", "САНХҮҮГИЙН САНАЛ" гэж хаяглан тус тусад нь битүүмжлэн дугтуйлна. Эдгээр дугтуйг өөр дугтуйд давхар хийж битүүмжилнэ. Гаднахь дугтуй дээр Төрийн өмчийн хорооны хаяг, тендерт оролцогчийн албан ёсны нэр, хаягийг бичиж:

"ГОВЬ ХК-ийн хувьцааг худалдан авах нууц санал - Тендерийн санал.
ШИНЖЭЭЧДИЙН БАГИЙГ БАЙЛЦУУЛАХГҮЙГЭЭР НЭЭХИЙГ ХОРИГЛОНО" гэсэн тэмдэглэл хийнэ.

Тендерийн саналыг Төрийн өмчийн хорооны дараахь хаягаар ирүүлнэ:

Л. Пүрэвдорж
Төрийн өмчийн хорооны дарга
Засгийн газрын IV байр, 410-р өрөө
Улаанбаатар-11, Монгол Улс

Тендерийн саналыг дээр дурдсан хаягаар 2003 оны 12 дугаар сарын 9-ний өдрийн (Улаанбаатарын цагаар) 18.00 цагаас өмнө ирүүлнэ.

**10.4. Техникийн санал**

Техникийн санал нь дор дурдсан хэсгүүдээс бүрдэнэ. Үүнд:

А.А. Тендерт оролцогчийн талаархи мэдээлэл. Үүнд:

(1) Тендерт оролцогчийн бизнесийн үйл ажиллагааны чиглэл, компанийн бүтэц, оёмол, сүлжмэл эдлэл, бэлэн хувцасны үйлдвэрлэлийн салбар дахь түүний (консорциумаар оролцож байгаа тохиолдолд хамтарч буй компаниудын) үйл ажиллагаа болон/буюу тендерт оролцогчийн техникийн түнш буюу удирдлагын багийн туршлагын талаар дэлгэрэнгүй танилцуулга,

(2) Сүүлийн гурван /3/ жилийн эцсийн байдлаар гаргаж аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан тэнцэл (хувьцаат компанийн хувьд хувьцаа эзэмшигчдэд зориулсан жилийн тайлан),

(3) Тендерт оролцогчийн нийт гаргасан буюу бусад хэлбэрээр өмчилж буй хувьцааны тав /5/-аас дээш хувийг эзэмшиж буй хувьцаа эзэмшигчдийн жагсаалт (консорциумаар оролцож байгаа тохиолдолд хамтарч буй компани тус бүрийн нийт гаргасан буюу бусад хэлбэрээр өмчилж буй хувьцааны 5 /тав/-аас дээш хувийг эзэмшиж буй хувьцаа эзэмшигчид тус бүрийг энэхүү жагсаалтанд оруулна),

(4) Тендерт оролцогчоос тендерт холбогдолтой гэж үзэн санал болгож буй бусад мэдээлэл.

Б. Бизнесийн стратеги/Үйл ажиллагааны төлөвлөгөө

Энэхүү стратеги/төлөвлөгөө нь тендерт оролцогчийн компанийг цаашид хөгжүүлэх бизнесийн стратегийг танилцуулах зорилготой бөгөөд түүнд хоёр /2/-оос доошгүй жилийг хамарсан дор дурдсан арга хэмжээг тусгасан байвал зохино. Үүнд:

(1) "Говь" ХК-ийн Монголын ноолуурыг ашиглан өндөр үнэ цэнэтэй, дээд зэрэглэлийн эцсийн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэхэд чиглэгдсэн боловсруулах хүчин чадал болон компанийн экспортыг нэмэгдүүлэх талаар санал болгож буй бизнесийн стратеги,
(2) Шинээр нэвтрүүлэх болон үйлдвэрлэлтийн хүчин чадлыг шинэчилж сайжруулахад зориулах технологи, ноу-хау-гийн талаархи дэлгэрэнгүй мэдээлэл болон хэрэгжүүлэх хөтөлбөр, гарах зардал, хөрөнгө оруулалт хийх хуваарийн хамт,
(3) Бүтээгдэхүүн, түүний ангилал тус бүрийн борлуулалтын тоо хэмжээний талаархи хоёр /2/ жилийн прогнозыг хамарсан Маркетингийн төлөвлөгөө,
(4) Түүхий эд бэлтгэлийн стратеги,
(5) Хоёр /2/ жилийг хамарсан санхүүгийн прогноз (орлого, үр дүнгийн тайлан, баланс, мөнгөн урсгалын тайлан),
(6) Ажиллагсдыг сургах, хүний нөөцийг хөгжүүлэхэд зориулах хөрөнгө оруулалтын хэмжээ, шинж чанарыг тусгасан хүний нөөцийг хөгжүүлэх төлөвлөгөө,
(7) Байгууллагын болон удирдлагын хөгжлийн төлөвлөгөө,
(8) Төлөвлөгөөт хугацаанд жил бүр шаардагдах Монголын харьяат бус техникийн мэргэжилтэн болон удирдлагын ажилтнуудын тоо, албан тушаал.
(9) Байгаль орчинд харш нөлөө үзүүлэхгүй бизнесийн үйл ажиллагаа явуулах төлөвлөгөө.

В. Тендерийн дэнчин төлснийг нотлох баримт

**Г. Тендерийн энэхүү журмын сүүлчийн хуудсанд гарын үсэг зурсан хуулбар.** Тендерт оролцогч нь Тендерийн журамд гарын үсэг зурснаар энэхүү журмын заалтыг сахин мөрдөх, түүнд тусгасан бүх нөхцөл, болзлыг хүлээн зөвшөөрснөө илэрхийлнэ.

Д. Тендерт оролцохыг зөвшөөрч **хуулийн этгээдийн удирдах байгууллагаас гаргасан шийдвэр** (консорциумаар оролцож байгаа тохиолдолд хамтарч буй хуулийн этгээд тус бүрийн удирдах байгууллагаас гарсан шийдвэр).

Е. Тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч **хувьцаа худалдах, худалдан авах гэрээний эцсийн төсөлд** зохих ёсоор гарын үсэг зурж бусад бүх байдлаар бэлэн болгосон байж бөгөөд зөвхөн худалдан авах үнийг оруулах зайг хоосон үлдээнэ. Хоосон үлдээсэн зайг тендерт

оролцогчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч зөвхөн ТӨХ-ны даргын урилгаар бөглөж гүйцээнэ.

Техникийн саналын эх хувьд хувьцаа худалдах, худалдан авах гэрээний эцсийн төслийн гарын үсэг зурсан бүх хувийг хавсаргана. Хувьцаа худалдах, худалдан авах гэрээний эцсийн төсөлд зориуд хоосон үлдээсэн хэсгийг тендерт оролцогчоор бөглүүлэхээс өөрөөр /худалдан авах үнийг оруулахаар хоосон үлдээсэн зайг оролцуулахгүйгээр/ ямар нэгэн өөрчлөлт оруулахыг үл зөвшөөрнө.

Хувьцаа худалдах, худалдан авах гэрээний эцсийн төсөлд дараахь зүйлийг хавсаргана. Үүнд:

(а) Хувьцаа худалдах, худалдан авах гэрээнд гарын үсэг зурахыг зөвшөөрсөн хуулийн этгээдийн удирдах байгууллагаас /буюу тендерт оролцогч консорциум болон оролцож байгаа тохиолдолд консорциумын гишүүн болох хуулийн этгээд тус бүрийн удирдах байгууллагын/ гаргасан шийдвэр,
**(б) Итгэмжлэгдсэн төлөөлөгчид** дараахь эрх олгосныг нотлох итгэмжлэл:
- Гэрээнд гарын үсэг зурах,
- Санхүүгийн саналыг нээх ажиллагаанд Тендерт оролцогчийг төлөөлөх.

Тендерт оролцогчийн өргөдөлд хавсаргасан итгэмжлэлд эдгээр эрхийг итгэмжлэгдсэн төлөөлөгчид олгосон тохиолдолд итгэмжлэлийн хувийг хавсаргана.

**10.5 Санхүүгийн санал**

Санхүүгийн санал нь "Говь" ХК-ийн нийт хувьцааны төрийн эзэмшлийн 70 хувьд ногдох 5,460,788 ширхэг хувьцааг ***худалдан авах үнээс*** бүрдэх бөгөөд энэ үнэ нь 11.6 (арван нэгэн сая зургаан зуун мянган) сая ам. доллараас доошгүй байна.

**11. ТЕНДЕРИЙН САНАЛЫН ҮНЭЛГЭЭ**

11.1. Төрийн өмчийн хороо тендерийн саналуудад үнэлгээ хийлгүүлэх зорилгоор шинжээчдийн багийг томилно. Тендерийн саналыг үнэлэх үйл ажиллагаа нь дараахь хоёр үе шаттай байна. Үүнд:

- Техникийн саналын үнэлгээ,
- Санхүүгийн саналын үнэлгээ.

11.2. Шинжээчдийн баг нь техникийн саналуудыг дор дурдсан шалгаруулах үзүүлэлтийг үндэслэн онооны системээр үнэлнэ. Үүнд:

1) Хөрөнгө оруулагчийн нэр хүнд, бизнесийн чадавхи, санхүүгийн байдал, салбарын туршлага (0-40 оноо),

2) Санал болгож буй менежментийн / маркетингийн/үйл ажиллагааны төлөвлөгөөний чанар, Засгийн газраас дэвшүүлж буй хувьчлалын зорилгыг хүлээн авч тусгасан байдал (0-60 оноо).

Дэд үзүүлэлт:

- Бизнесийн стратеги, үйл ажиллагааны төлөвлөгөөний цар хүрээ, тодорхой байдал (0-10 оноо),
- Төлөвлөгөө, стратеги нь Засгийн газраас дэвшүүлж буй хувьчлалын зорилгод нийцсэн байдал (0-20 оноо),
- Зардал болон хөрөнгө оруулалт хийх хуваарийг тусгасан компанийн техник, тоног төхөөрөмжийг сайжруулах зорилго бүхий техникийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөө (0-10 оноо),
- Байгаль орчинд харш нөлөө үзүүлэхгүй бизнесийн үйл ажиллагаа явуулах төлөвлөгөө (0-10 оноо),
- Хүний нөөцийг хөгжүүлэх төлөвлөгөө, ажиллагсдыг сургах зэрэг хүний хүчин зүйлийг хөгжүүлэхэд оруулах хөрөнгө оруулалтын цар хүрээ, шинж чанар (0-10 оноо).

11.3. Техникийн үнэлгээгээр 70-аас доошгүй оноо авсан саналыг шалгаруулна.

11.4. Техникийн саналыг үнэлэх үйл ажиллагааг дуусгасны дараа шинжээчдийн баг нь техникийн саналын үнэлгээний тайлан гаргана.

11.5. Техникийн үнэлгээ дууссаны дараа Төрийн өмчийн хороо техникийн саналын үнэлгээгээр авбал зохих доод онооны болзлыг хангаж тэнцсэн оролцогчдод цаашид тендерт үргэлжлүүлэн оролцохоор шалгарсан тухай санхүүгийн саналыг нээхээр товлосон газар, цагийг заан мэдэгдэнэ. Үүний зэрэгцээ Төрийн өмчийн хороо техникийн саналын үнэлгээгээр авбал зохих доод онооны болзлыг хангаагүй оролцогчдод цаашид тендерт оролцохоор шалгараагүй болон дэнчинг буцаан олгох тухай мэдэгдэнэ. Мэдэгдлийг буухиа шуудан, баталгаат захиа, факс буюу электрон шуудангаар явуулж болно.

11.6. Санхүүгийн саналуудыг тендерт оролцогчдын итгэмжлэгдсэн төлөөлөгчдийг байлцуулан нийтийн өмнө тендерийн хуваарьт заасны дагуу 2003 оны 12 дугаар сарын 16-ны өдөр задлана.

11.7. Техникийн саналын үнэлгээгээр 70-аас доошгүй оноо авсан тендерт оролцогчдын санхүүгийн саналыг нээж үнэлнэ.

11.8. Тендерт оролцогчийн нэр болон "Говь" ХК-ийн нийт хувьцааны төрийн эзэмшлийн 70 хувьд ногдох хувьцааг худалдаж авахаар санал болгож буй худалдан авах үнийг чангаар уншиж, бүртгэнэ. Шинжээчдийн баг техникийн саналын эх хувьд хувьцаа худалдах, худалдан авах тухай гэрээний эцсийн төслийг хавсаргаж, зохих ёсоор гарын үсэг зурсан эсэхийг шалгах ба санхүүгийн саналуудыг нийтийн өмнө задлах ажиллагааны тэмдэглэл хөтөлнө.

11.9. Санхүүгийн саналдаа хамгийн өндөр худалдан авах үнийн санал ирүүлсэн оролцогчийг тендерийн ялагчаар шалгаруулна.

11.10. Хоёр буюу түүнээс олон тендерт оролцогчид ижил үнийн санал ирүүлсэн тохиолдолд тэдгээрийг техникийн саналын үнэлгээгээр авсан онооны дагуу эрэмбэлнэ. Хэрэв техникийн саналын үнэлгээгээр авсан оноо нь мөн тэнцвэл худалдан авах үнийн шинэ саналыг нэг цагийн дотор бичгээр өгөх боломж олгоно. Шаардлагатай тохиолдолд энэ ажиллагааг аль нэг тендерт оролцогч нь илүү өндөр үнийн санал ирүүлэх хүртэл үргэлжлүүлэн явуулна.

11.11. Санхүүгийн саналыг албан ёсоор нээж үнэлсэн өдрөө шинжээчдийн баг нь тендерийн үр дүнгийн мэдэгдэл /тэмдэглэл/-ийн төслийг бэлтгэж, Төрийн өмчийн хороогоор хянуулан батлуулах зорилгоор нээлттэй хуралдааны ажиллагааг түр завсарлана.

11.12. Шинжээчдийн баг, Төрийн өмчийн хорооны гишүүд мөн өдөр нээлттэй хамтарсан хуралдаан хийж, Төрийн өмчийн хорооны даргын гарын үсэг зурсан тендерийн үр дүнгийн мэдэгдэл / тэмдэглэл/-ийг уншиж тендерийн үр дүнг зарлана.

11.13. Ялагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийг тендерийн үр дүнгийн мэдэгдэл / тэмдэглэл/-д гарын үсэг зурж, хувьцаа худалдах, худалдан авах гэрээнд ялагчийн худалдан авах үнийг оруулахаар урих бөгөөд түүнд уг мэдэгдлийн гарын үсэг зурсан хувийг, хуудас бүр дээр Төрийн өмчийн хорооны даргын гарын үсэг зурж үзэглэсэн хувьцаа худалдах, худалдан авах тухай гэрээний хувьтай хамт олгоно.

## 12. ТЕНДЕРИЙГ ЯВАГДААГҮЙД БОЛОН ХҮЧИНГҮЙД ТООЦОХ, ӨРГӨДӨЛ, САНАЛ ИРҮҮЛЭХ ХУГАЦААГ СУНГАХ

12.1. Төрийн өмчийн хороо өргөдөл, санал ирүүлэх хугацааг өөрийн санаачилгаар эсвэл тендерт оролцогчийн хүсэлтийн дагуу сунгах буюу тендерийн хуваарийг хэдийд ч ямар ч байдлаар өөрчилж болно.

12.2. Монгол Улсын Засгийн газар нь аль ч үед урьдчилан мэдэгдэлгүйгээр уралдаант шалгаруулалт /тендер/-ын журмын аль ч заалтыг хасах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах эрхтэй. Тендерийн журамд оруулсан аливаа өөрчлөлтийн талаар Төрийн өмчийн хороо бүх оролцогчдод бичгээр мэдэгдэнэ.

Тендерт оролцогчийн гарын үсэг ____________________

Он, сар, өдөр ____________________

**ХАВСРАЛТ 1**

### ТЕНДЕРИЙН ХУВААРЬ

| | |
|---|---|
| **Тендерийн зар мэдээ** | 2003 оны 6-р сарын 3 |
| Тендерт оролцох өргөдөл/хүсэлтээ ирүүлэх | 2003 оны 6-р сарын 3 - 9-р сарын 16 |
| Урьдчилсан шалгаруулалт/Тендерийн баримт бичгийг хүргүүлэх | 2003 оны 6-р сарын 17 - 9-р сарын 30 |
| Компани дээр дүн шинжилгээ хийх/санал, дүгнэлт гаргах хугацаа | 2003 оны 6-р сарын 17 - 11-р сарын 28 |
| Хувьцаа худалдах, худалдан авах гэрээ (ХХХАГ)-ний талаар санал авах | 2003 оны 10-р сарын 14 |
| ХХХАГ-ний шинэчилсэн төслийг боловсруулан гаргах | 2003 оны 10-р сарын 28 |
| ХХХАГ-ний шинэчилсэн төслийн талаар санал авах | 2003 оны 11-р сарын 11 |
| ХХХАГ-ний эцсийн төслийг бэлтгэн гаргах | 2003 оны 11-р сарын 25 |
| **Тендерийн санал ирүүлэх** | 2003 оны 12-р сарын 9 |
| Техникийн саналыг үнэлэх | 2003 оны 12-р сарын 10 - 12-р сарын 15 |
| Санхүүгийн саналыг нийтийн өмнө нээж үнэлэх/Тендерийн үр дүнг нийтэд мэдээлэх | 2003 оны 12-р сарын 16 |
| **Гэрээнд гарын үсэг зурах** | 2003 оны 12-р сарын 16 |

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
**Хаяг: <<Төрийн мэдээлэл>> эмхтгэлийн зөвлөл.**
Улаанбаатар- 12
Төрийн ордон
☎ 329612
Индекс 14003
Улсын Их Хурлын Тамгын газрын
Хэвлэх хэсэгт хэвлэв.
☎ 329487
Хэвлэлийн хуудас 2.5